



Монгол Улсын Хараат Бус Тайлан: 2014-2016 оны эцсийн тайлан

Монгол улсын эхний Үйл Ажиллагааны Үндэсний Төлөвлөгөө (ҮАҮТ)-ний зорилтуудын тал хувь нь томоохон өөрчлөлт гаргах боломжтой амбиц өндөртэй байлаа. Тайлангийн хугацааны төгсгөлд байгаль орчны ил тод байдал, төсвийн мэдээлэл иргэдэд хүрэх байдал, гэмт хэргийн гаралтын газрын зураг гаргах зэрэг чиглэлээр чухал ахиц дэвшил гаргасан болно. Гэвч ихэнх зорилтууд нь бүрэн хэрэгжээгүй болно. Монгол улсын 2-р ҮАҮТ нь өмнөх зарим зорилтуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба мөн нээлттэй засаглалыг боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлийн салбарт нэвтрүүлэх болсон.

Нээлттэй Засгийн Түншлэл (НЗТ) нь төр, засгийн зүгээс иргэд, олон нийтийн тусын тулд ил тод байдлыг хангах, иргэдийг хүчтэй болгох, авлигатай тэмцэх, засаглалыг бэхжүүлэх зорилгоор шинэ технологийг нэвтрүүлж ашиглахад чиглэсэн, улс орнуудын сайн дурын олон талт санаачлага юм. Хараат Бус Тайлагналын (ХБТ) механизм нь НЗТ-д оролцогч улс дахь хэрэгжилтын явцыг хоёр жил тутамд дүгнэн шинжилдэг. Энэхүү тайлан Монгол улсын эхний ҮАҮТ-ний 2015 оны 7-р сараас 2016 оны 6-р сарын хоорондох хоёр дахь жилийн хэрэгжилтийг хамарсан болно.

Монгол улс эхний ҮАҮТ-гөө 2013 оны 3-р сараас 2014 оны 5-р сарын хооронд боловсруулан гаргасан. ЗГХЭГ Монгол улсын НЗТ-ийн үйл явц, зорилтуудыг хариуцан ажилладаг. 2013 оны 11-р сард ЗГХЭГ яамдууд болон иргэний нийгмийн зарим төлөөллийг оролцуулан НЗТ-ийн Үндэсний Зөвлөлийг байгуулсан. Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) ҮАҮТ-г боловсруулах болон хэрэгжүүлэхэд оролцсон. Засгийн газар өөрийн үнэлгээний эцсийн тайланг 2017 оны 2-р сард хүргүүлсэн болно.

2016 оны 6-р сарын 7-нд НЗТ-ийн Үндэсний Зөвлөл Монгол улсын хоёр дахь ҮАҮТ-г баталсан. Энэхүү төлөвлөгөө нь төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн шударга байдлыг нэмэгдүүлэх, нийтийн баялгийг илүү үр дүнтэй удирдах, компаний хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зэрэг НЗТ-ийн 4 гол сорилыг хамруулсан 13 зорилтоос бүрдэнэ. Эхний ҮАҮТ-с 7 зорилт үргэлжлэн илүү өргөн хэлбэрээр

Хүснэгт 1: Товчхон			
		<i>Дунд хугацааны</i>	<i>Эцсийн</i>
Зорилтын тоо		21	
<i>Хэрэгжилтийн түвшин</i>			
Бүрэн хэрэгжсэн		1	3
Ихэнх нь		4	6
Хязгаарлагдмал		10	6
Эхлээгүй		6	6
<i>Дараах шаардлагад нийцсэн зорилтууд:</i>			
НЗТ-ийн үнэт зүйлстэй тодорхой холбоотой		18	
Томоохон үр нөлөө бүхий		9	
Ихэнх нь буюу бүрэн хэрэгжсэн		5	9
<i>Гурвууланг нь (⊕)</i>		2	3
<i>Засгийг нээлттэй болгосон уу?</i>	Томоохон	N/A	3
	Дорвитой	N/A	0
<i>Цааш үргэлжилсэн байдал</i>			
Дараагийн ҮАҮТ-д үргэлжлэн орсон зорилтын тоо		7	

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

хэрэгжихээр орсон бөгөөд мөн боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн салбарыг хамарсан зорилтууд орсон болно.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Хэрэгжүүлэх явцад иргэний нийгмийн төлөөлөлтэй зөвлөлдсөн байдал

НЗТ-д оролцогч улсууд ҮАҮТ-гөө боловсруулах болон хэрэгжүүлэх явцдаа зөвлөлдөх үйл явцыг зохион байгуулдаг. Монгол улсын эхний ҮАҮТ-гөө боловсруулах явцад ИНБ-ууд болон иргэд идэвхтэй оролцсон. Монгол улсын Ерөнхийлөгч 2013 оны 8-р сард Иргэний танхимд ҮАҮТ-ний төслийн талаар нээлттэй хэлэлцүүлэг явуулсан болно. Энэхүү хэлэлцүүлэгт Нээлттэй Нийгэм Форум, Иргэдийн Альяанс Төв, Гамшгийн Судалгааны Төв, Ардчилалын Боловсрол Төв, Байгаль Орчны Иргэний Зөвлөл, Хөвсгөл Далайн Эзэд Хөдөлгөөн зэрэг байгууллагууд оролцсон. Засгийн газар болон иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг үүний дараа олон санал, зөвлөмж авсан болно. Мөн аймгуудад хэлэлцүүлэг хийгдсэн. Хэдийгээр эцсийн хувилбарыг иргэдийн оролцоогүйгээр баталсан боловч ерөнхийдөө ҮАҮТ-г боловсруулах явцад иргэд идэвхтэй оролцсон болно.

Харин ҮАҮТ-г хэрэгжүүлэх явцад Засгийн газрын зүгээс иргэдтэй зөвлөлдөх тодорхой механизм байгаагүй болно. Транспэрэнси Интернэйшнл байгууллагын Монгол дахь салбараас 2015 оны 1-р сарын 15-нд НЗТ-ийн үйл явцын талаар хурал зохион байгуулсан. Хуралд Засгийн газрыг төлөөлж НЗТ-ийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга оролцож 2014 онд төрийн байгууллагууд ҮАҮТ-ний зорилтуудыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар илтгэл тавьсан болно. ХБТ-ын судлаачид үүнийг дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх ёстой, НЗТ-ийн шаардлагыг хангасан байнгын, оролцогч талуудыг хамарсан хэлэлцүүлэг гэж үзэхгүй байна.

Төрийн яамд, ИНБ-уудын оролцоотой НЗТ-ийн Үндэсний зөвлөл ч үүргээ биелүүлж чадсангүй. Ерөнхий сайдын 207 тоот захирамжаар 2015 оны 10-р сард бүтцээ өөрчилсөн Үндэсний Зөвлөл 2016 оны 2-р сард хуралдаж эхний ҮАҮТ, өөрийн үнэлгээний тайлан, хараат бус тайлан, 2-р ҮАҮТ-ний төслийг хэлэлцсэн болно. 2-р ҮАҮТ-нд дурдсанаар ЗГХЭГ илүү өргөн оролцоотой ажлын хэсэг байгуулж ҮАҮТ-ний хэрэгжилтийг хянах олон талт хэлэлцүүлгийн боломжийг бүрдүүлэх юм.

Хүснэгт 2: ҮАҮТ-ний зөвлөлдөх үйл явц

ҮАҮТ-ний үе шат	НЗТ-ийн үйл явцын шаардлага (Засаглалын бүлгийн зүйл анги)	Засгийн газар энэ шаардлагыг хангасан уу?
Хэрэгжүүлэх явцад	Хэрэгжүүлэх явцад байнгын зөвлөлдөх үүлзалтууд хийсэн үү?	Үгүй
	Зөвлөлдөх үүлзалтууд нээлттэй зарлагдсан уу эсвэл зөвхөн урилгаар?	Хамааралгүй
	Зөвлөлдөх үүлзалт IAP2 spectrum дагуу болсон үү?	Хамааралгүй

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилтуудын хэрэгжилтэд гарсан ахиц дэвшил

ХБТ-ын судалгаанд ашиглагдсан бүх үзүүлэлт болон аргачлалын талаар ХБТ-гийн гарын авлагаас (<http://www.opengovpartnership.org/about/about-irm>) дэлгэрэнгүй танилцаж болно. Уншигчдын хувьд анхаарал татахуйц үзүүлэлт бол одтой зорилтууд юм. Одоор тэмдэглэгдсэн үзүүлэлтүүд нь НЗТ-ийн үлгэр жишээ зорилтууд болно. Одтой тэмдэглээтэй болохын тулд зорилтууд нь дараах хэдэн шаардлагыг хангах ёстой. Үүнд:

1. *Боломжит нөлөөллийг үнэлэх үнэлгээ нь тодорхой байх ёстой. Өндөр эсвэл дунд зэргийн ач холбогдолтой байна.*
2. *Нээлттэй засаглалын үзэл санаатай хамаарал нь тодорхой байна. Тухайлбал мэдээллийн хүртээмжтэй байдал, иргэдийн оролцоо, төрийн хариуцлагатай байдал зэрэг НЗТ-ийн үнэт зүйлсийн ядаж нэгд нь хамааралтай байна.*
3. *Бүрэн хэрэгжсэн тохиолдолд томоохон үр нөлөөтэй байх.*
4. *ҮАҮТ-г хэрэгжүүлэх явцад тухайн зорилтын талаар мэдэгдэхүйц ахиц гарсан байх, мөн төлөвлөгөөний хэрэгжилт дуусах үед бүрэн биелсэн байх.*

Дээрх шалгууруудын дагуу явцын тайланд Монгол улсын ҮАҮТ-ний хоёр зорилт од авсан. Харин эцсийн тайланд хэрэгжилтийн түвшинг харгалзан үзэж гурван зорилт од авсан болно. Үүнд:

- 3.3.1.3: *Нээлттэй дансны систем*
- 3.3.1.7 *Гадаадын зээл тусламжийн төслүүд*
- 3.3.1.6: *Байгаль орчны мэдээллийг олон нийтэд заавал нээлттэй болгох*

Засгийг нээлттэй болгосон уу?

НЗТ-ийн зорилтууд ихэнх тохиолдолд ерөнхий үтгатай, нээлттэй засагтай хэрхэн холбогдож буй нь тодорхой бус байдаг боловч улс төрийн дорвитой шинэчлэл болдог. Засгийн газрын үйл ажиллагаанд ямар өөрчлөлт гарсаныг дүгнэхийн тулд ХБТ-аас “Засгийг нээлттэй болгосон уу?” гэсэн хувьсагчийг эцсийн тайланд оруулсан болно. Энэхүү хувьсагч нь гарсан үр дүн, ажлыг хэмжихээс илүү гүнзгийгээр засгийн газрын үйл ажиллагаа зорилтуудын хэрэгжилтийн явцад хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзнэ. Үүгээрээ боломжит үр нөлөөг тооцдог “одтой зорилтуудаас” ялгаатай юм.

ХБТ-ын судлаачид “Засгийг нээлттэй болгосон уу?” хувьсагчийг тухайн зорилтын НЗТ-ийн хамааралтай үнэт зүйлс болгоноор дүгнэнэ. Энэ нь засгийн газрын ердийн ажлын арга барил өөрчлөгдсөн эсэхийг авч үзнэ. Үзүүлэлтүүд нь:

- **Муудсан:** зорилтын хүрээнд авсан арга хэмжээнүүдийн үр дүнд засгийн газрын нээлттэй байдал муудсан
- **Өөрчлөгдөөгүй:** засгийн газрын үйл ажиллагаа өөрчлөгдөөгүй
- **Бага зэрэг:** нээлттэй байдлын түвшинд нөлөөлж чадахааргүй бага зэргийн өөрчлөлт
- **Томоохон:** холбогдох бодлогын хүрээнд засгийн газрын нээлттэй байдалд ахиц дэвшил гаргасан ч хамрах цар хүрээний хувьд хязгаарлагдмал
- **Дорвитой:** холбогдох бодлогын хүрээнд засгийн газрыг нээлттэй болгож өмнөх ажил явуулдаг арга барилыг өөрчилсөн

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Энэхүү хувьсагчийг дүгнэхийн тулд ҮАҮТ-г хэрэгжүүлж эхлэхэд ямар байдалтай байсныг тогтооно. Дараа нь засгийн газрын нээлттэй байдал хэрхэн өөрчлөгдсөнийг гарсан үр дүнгээр нь тооцож тогтооно.

Уншигчид ХБТ-ын эцсийн тайлангийн хэрэгжүүлэх үе шат дуусаад хэдхэн сар өнгөрсний дараа гардаг болохыг анхаарна үү. Хувьсагч нь хоёр жилийн хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд засгийн газрын нээлттэй байдлын чиглэлд гарсан үр дүнд төвлөрнө. Нарийн төвөгтэй аргачлал, цаг хугацаанаас хамаарч энэхүү тайлан нь үр нөлөөг үнэлэх зорилго агуулаагүй болно.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилтуудын ерөнхий тойм

НЗТ-ийн хүрээнд улс орнууд 2 жилийн хугацаатай ҮАҮТ-г боловсруулан зорилтууд тавьдаг. Эцсийн тайланд “Засгийг нээлттэй болгосон үү?” гэсэн нэмэлт үзүүлэлт ордог. Доорхи хүснэгтэд энэхүү үзүүлэлт болон зорилтуудын хэрэгжилтийн түвшинг хураангуйлан оруулсан болно. Дунд хугацаанд бүрэн хэрэгжсэн зорилтуудын хувьд зөвхөн “Засгийг нээлттэй болгосон үү?” үзүүлэлтээр дүн шинжилгээ хийсэн болно. Өмнө хэрэгжиж дууссан зорилтуудын тухай нэмэлт мэдээлэл авахаар бол дунд хугацааны хараат бус тайланг үзнэ үү.

Засгийн газар өөрчлөгдсөн болон 2016 оны 6-р сард УИХ-ын сонгууль болсон нь зорилтуудыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөв. ҮАҮТ-ний монгол (www.zasag.mn/tunshlel) болон англи (www.opengovpartnership.org.country.mongolia) хувилбарууд дээр зарим зорилтууд зөрүүтэй байв. Засгийн газрын төлөөлөлийн зүгээс энэ талаар ямарваа нэг тайлбар өгөөгүй ба эдгээр нь ихэнхдээ бага хэмжээнийх байсан нь үнэлгээ хийхэд нөлөө үзүүлээгүй болно.

Монголын үйл ажиллагааны төлөвлөгөө нь 21 зорилтоос бүрдэнэ. ХБТ-ын ажилтан болон Монголын судлаачид эдгээр зорилтыг сэдэвчилсэн 7 бүлэгт хувааж дүгнэлт хийсэн:

- 1-р бүлэг: Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах
- 2-р бүлэг: Төсөв, санхүүгийн ил тод байдал
- 3-р бүлэг: Байгалийн нөөц баялгийн ашиглалтын ил тод байдал
- 4-р бүлэг: Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- 5-р бүлэг: Төрийн үйлчилгээг сайжруулах
- 6-р бүлэг: Хууль сахиулах үйл ажиллагааг сайжруулах
- 7-р бүлэг: Төрийн албаны шударга байдлыг бэхжүүлэх

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Хүснэгт 3. Зорилтуудын хэрэгжилтийн ерөнхий тойм

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэтгэл		Хунд хугацааны: Эцсийн		Засгийг нээлттэй болгосон уу?				
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээлэлтйин	Иргэний оролцоо	Нийгмийн хариуцлагатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой
1-р бүлэг: Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах																					
3.3.1.1: Төрийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх			✓		✓		✓							✓				✓			
3.3.1.2: Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг “иргэн төвтэй” болгож шинэчлэх		✓			✓	✓	✓						✓					✓			
2-р бүлэг: Төсөв, санхүүгийн ил тод байдал																					
✪ 3.3.1.3: Төсвийн ил тод байдлыг хангах				✓	✓		✓	✓				✓									✓
✪ 3.3.1.7: Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг ил тодболгох				✓	✓							✓							✓		
3.3.1.8: Төсвийн хөрөнгө оруулалттай 80 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авахажиллагааны гэрээг ил тод болгох				✓	✓						✓								✓		
3-р бүлэг: Байгалийн нөөц баялгийн ашиглалтын ил тод байдал																					
3.3.1.4: Ашигт малтмал, газрын тос, болон тусгай зөвшөөрлийн ил тод байдал			✓		✓		✓					✓		✓					✓		

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэт гэл		Хунд хугацааны: Эцсийн		Засгийг нээлттэй болгосон уу?				
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээлэлтийн	Иргэний оролцоо	Нийгмийн хариуцлагатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой
3.3.1.5: Ашигт малтмал, газрын тос, газар, ус ашиглах гэрээний ил тод байдал				✓	✓							✓		✓					✓		
3.3.1.6: Байгаль орчны талаарх мэдээллийн ил тод байдал				✓	✓							✓		✓						✓	
4-р бүлэг: Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх																					
3.3.2.1: Төрийнүйлчилгээг сайжруулахад иргэдийн оролцоог хангах			✓			✓							✓							✓	
3.3.2.6: Засгийн газрын “11-11” иргэдийн санал гомдлын төвд хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулахад тусгадаг болгох				✓	✓	✓	✓	✓											✓		
3.3.3.5: Иргэдийн ашиг сонирхолтой зөрчилдсөн, иргэдийн оролцоогүйгээр гарсан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох журам гаргах			✓			✓	✓						✓						✓		
3.3.3.7: Зорилтот бүлгүүдэд чиглэсэн эрх зүйн боловсрол олгох		✓			✓	✓							✓	✓					✓		
5-р бүлэг: Төрийн үйлчилгээг сайжруулах																					
3.3.2.2: Төрийнүйлчилгээг цахимжуулах			✓		✓														✓		✓

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэт гэл		Хунд хугацааны: Эцсийн		Засгийг нээлттэй болгосон уу?					
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээлэлтийн	Иргэний оролцоо	Нийгмийн хариуцлагатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой	
3.3.2.3: Нэг цонхны үйлчилгээг цахимжуулах		✓			Тодорхойгүй					✓			✓					✓				
3.3.2.4: Төрийн захиргааны үйлчилгээний нэгдсэн стандарт бий болгох			✓		Тодорхойгүй					✓			✓					✓				
3.3.2.5: ТҮЦ машины тоог нэмэгдүүлэх				✓	✓		✓			✓			✓	✓				✓				
3.3.3.6: Хуулийн төсөл, захиргааны журам болон тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтийнтала арх мэдээллийг тухайн цаг үед нь олон нийтэд хүргэх				✓	✓		✓				✓	✓						✓				
6-р бүлэг: Хууль сахиулах үйл ажиллагааг сайжруулах																						
3.3.3.1: Гэмт хэргийн гаралтын "цахим газрын зураг"-ийг ажиллуулах			✓		✓		✓			✓			✓			✓					✓	
3.3.3.2: Хууль сахиулах үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн тогтолцооны нэгдсэн сан бүрдүүлэх			✓		Тодорхойгүй					✓			✓			✓		✓				
7-р бүлэг: Төрийн албаны шударга байдлыг бэхжүүлэх																						
3.3.3.3: Нийтийн албан хаагчдын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг санам саргүй сонголтын аргаар шалгах			✓		✓	✓	✓			✓		✓						✓				

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэт гэл		Хунд хугацааны: Эцсийн		Засгийг нээлттэй болгосон уу?				
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээлэлтийн	Иргэний оролцоо	Нийгмийн хариуцлагатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой
арга нэвтрүүлэх																					
3.3.3.4: Авлигын индекс өндөртэй байгууллагуудын нийтийн албан тушаалтны хөрөнгөорлого, ашиг сонирхлын мэдүүлгийг цахим мэдээллийн сүлжээнд байрлуулах			✓		✓	✓	✓				✓	✓						✓			

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

I-р бүлэг: Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах

3.3.1.1: Мэдээллийн ил тод байдлын Үндэсний зөвлөл байгуулж, мэдээллийн комиссарын бүтцийг бий болгосноор “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх”-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих.

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулинд” нэмэлт, өөрчлөлт оруулж УИХ-д өргөн барих.

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/7/14

3.3.1.2: Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг “иргэн төвтэй” болгож шинэчлэх

Төрийн байгууллагын гүйцэтгэлийг илтгэх үзүүлэлтийг ил тод байлгах.

Гүйцэтгэлийг илтгэх шалгуурыг үнэлж НЗТ-ийн Үндэсний зөвлөлд тайлагнах.

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 30/9/14

Хэрэгжүүлэх байгууллага: Засгийн газар, УИХ, ИНБ

Хамтран ажиллах байгууллага: Тодорхойлоогүй

Редакцийн тэмдэглэл: ХБТ-ын судлаачид мэдээллийн ил тод байдлыг сайжруулах бүлэгт эдгээр зорилтуудыг сонгон авч, дүн шинжилгээ хийлээ.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэтгэл		Дунд хугацааны Эцсийн		Засгийг нээлттэй болгосон уу?					
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээлэлтийн	Иргэний оролцоо	Нийгмийн харилцаатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой	
3.3.1.1: Төрийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх			✓		✓		✓				✓			✓				✓				
3.3.1.2: Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг “иргэн төвтэй” болгож шинэчлэх		✓			✓	✓	✓		✓				✓					✓				

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилго

Энэ 2 зорилт нь мэдээллийг олон нийтэд илүү хүртээмжтэй хүргэхийн тулд ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой. Эхний зорилт нь (3.3.1.1) Мэдээллийн ил тод байдлын Үндэсний зөвлөл байгуулж, мэдээллийн комиссарын бүтцийг бий болгосноор “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх”-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих, хоёрдугаар зорилт нь (3.3.1.2) ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах.

Хэрэгжсэн байдал

Зорилт 3.3.1.1

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

2009 оны 6 дугаар сард УИХ-аас “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийг баталсан бөгөөд уг хуульд нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв, худалдан авах ажиллагаа зэрэг дөрвөн чиглэлээр ил тод байдлыг хангах талаар заажээ.

2014 оны 7-р сард энэхүү хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж 9 дүгээр зүйл (Төсөв, санхүүгийн ил тод байдал) болон 10 дугаар зүйлийг (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал) тус тус хассан. Эдгээр хасагдсан зүйлүүд “Шилэн дансны тухай хууль”-ийн нэг хэсэг болов.

Гэвч эдгээр өөрчлөлтөд Мэдээллийн ил тод байдлын Үндэсний зөвлөл, мэдээллийн комиссарыг байгуулах тухай заалт ороогүй. Тиймээс эхний жилийн хугацаанд уг зорилтын хэрэгжилтийг хязгаарлагдмал гэж үзэв.

Эцсийн хугацаанд: Хязгаарлагдмал

Засгийн газрын өөрийн үнэлгээний тайлан болон ХБТ-ын судлаачдын олж тогтоосноор Мэдээллийн ил тод байдлын Үндэсний зөвлөл, мэдээллийн комиссарыг байгуулах талаар ямар нэг ахиц дэвшил гараагүй.¹ Засгийн газрын зүгээс иргэний нийгэмтэй ямар нэг хэлэлцүүлэг хийгээгүй бөгөөд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулаагүй. Засгийн газрын тайлагнаснаар төрийн байгууллагууд вэб хуудсаа шинэчилж, нийгмийн сүлжээнүүдтэй холбон, мэдээллийн ил тод байдлын стратеги боловсруулан баталсан байна.²

Зорилт 3.3.1.2

Дунд хугацаанд: Эхлээгүй

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн 143-р тогтоолоор төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг баталсан. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал; хүний нөөцийн ил тод байдал; төсөв, санхүүгийн ил тод байдал; төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн 4 бүлэг бүхий 30 шалгуур үзүүлэлт багтажээ. Эхний жилд эдгээр үзүүлэлтийг шинэчлэх ямар нэг ажил хийгдээгүй болно.

Эцсийн хугацаанд: Эхлээгүй

ХБТ-ын судлаачид тайлант хугацааны 2 дахь жилд ямар нэг ахиц дэвшил гарсан гэсэн баримт олоогүй болно. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүд “иргэн төвтэй” болоогүй. Засгийн газар ХЭГ-ын даргын 88-р тушаал болон шударга байдлын шинэ шалгуур үзүүлэлтүүдийг дурьдсан байна. Уг тушаал нь мэдээлийн ил тод байдлын шалгуур

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

үзүүлэлтийн талаар бус, харин засаглалын асуудалд төвлөрсөн байна. Авилгатай Тэмцэх Газар (АТГ) 2015 оны сүүлчээр шударга байдлын шинэчилсэн судалгааг гаргасан.

³Энэхүү судалгааг 2010 оноос хойш гаргаж байгаа бөгөөд ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдэд төвлөрөөгүй болно.

Засгийг нээлттэй болгосон уу?

Зорилт 3.3.1.1

Мэдээллийн хүртээмжтэй байдал: Өөрчлөгдөөгүй

Төрийн шударга байдал: Өөрчлөгдөөгүй

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу иргэд мэдээлэл олж авах эрхийг нь хязгаарласан дурын байгууллага, албан тушаалтаны талаархи гомдлоо Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) болон шүүхэд гаргах боломжтой. Энэ тохиолдолд ХЭҮК мэдээллийн комиссарын хийж гүйцэтгэх ёстой хэд хэдэн арга хэмжээг авдаг. Ийм учраас Мэдээллийн Ил Тод Байдлын Үндэсний Зөвлөл, мэдээллийн комиссарыг бий болгох өндөр үр нөлөөтэй байлаа. Гэвч энэхүү зорилт хэрэгжээгүй учир засгийн нээлттэй байдалд ямар нэг өөрчлөлт гараагүй болно.

Зорилт 3.3.1.2

Мэдээллийн хүртээмжтэй байдал: Өөрчлөгдөөгүй

Иргэний оролцоо: Өөрчлөгдөөгүй

Төрийн шударга байдал: Өөрчлөгдөөгүй

ҮАҮТ-ний хэрэгжилтийн хугацаанд ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүд шинэчлэгдээгүй болно. Энэхүү зорилт хэрэгжээгүй учраас өмнөх нөхцөл байдал өөрчлөгдөөгүй.

Дараагийн ҮАҮТ-нд орсон эсэх

Энэхүү зорилтууд Монгол улсын 2-р ҮАҮТ-нд ороогүй. Мөн 2016 оны 2-р сард болсон олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр гаргасан зорилтуудад оруулах 28 саналд тусгагдаагүй.

¹ ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016. (Нээлттэй Засаг Түншлэл. 2016) <http://bit.ly/2tnPaYS>

² Өмнөх эх сурвалжтай адил

³ АТГ. Шударга байдлын үнэлгээний тайлан (2016.06.17). <http://www.iaac.mn/news/2316>.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

2-р бүлэг: Төсөв, санхүүгийн ил тод байдал

3.3.1.3: Төсвийн ил тод байдлыг хангах, олон нийтэд тогтмол мэдээлэх 'Шилэн дансны систем'-ийг нэвтрүүлж, төсвийн бүрдүүлэлт, орлого, зарлагын задаргаа, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хөрөнгө оруулалтийн хэрэгжилт, үр дүнгийн талаар иж бүрэн мэдээллээр хангах.

- Төсвийн бүрдүүлэлт, орлого, зарлагын задаргааны талаар иж бүрэн мэдээллээр хангах,
- Төсвийн байгууллагын жил бүрийн төсвийн санал, энэхүү саналыг боловсруулахад ашигласан норм, норматив, санхүүгийн бус нэмэлт мэдээллийг Засгийн газрын цахим хуудсанд ойлгомжтой хэлбэрээр байршуулах,
- Төсвийн байгууллагын албан хаагчдад төсвөөс үзүүлсэн дэмжлэгийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд нээлттэй байлгах,
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн болон хийгдэж байгаа төслүүдийн гүйцэтгэлийн тайлан, хэлэлцэх шатанд яваа төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн хураангуйг нийтлэх,
- Төсвийн байгууллагад хувь хүн, байгууллагаас өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдлыг хангах, иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулж ажиллуулах,

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

3.3.1.7: Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн жагсаалт, тэдгээрийн гэрээний мөнгөн дүн, зээлийн буцаан төлөлт болон хүүтэй холбоотой үндсэн нөхцлийн мэдээлэл, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх нэгжийн талаарх мэдээллийг нийтэд ил болгох. Төслийн хэрэгжилтийн нөхцөл, нийлүүлэгч болон худалдан авагчийн хооронд хийсэн гэрээний ерөнхий нөхцөл зэрэг мэдээллийг мөн ил болгох.

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

3.3.1.8: Төсвөөс санхүүжилттэй 80 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авах ажиллагааны гэрээг ил тод болгох.

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

Хэрэгжүүлэх байгууллага: Засгийн газар, ЗГХЭГ, ИНБ, Үндэсний аудитын хороо, СЯ, ХААГ, Аймаг, Нийслэлийн Засаг дарга

Хамтран ажиллах байгууллага: Тодорхойлоогүй

Редакцийн тэмдэглэл: ХБТ-ын судлаачид төсөв, санхүүгийн ил тод байдлын бүлэгт эдгээр зорилтыг сонгон авч, дүн шинжилгээ хийлээ.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэтгэл		Хунд хугацааны:	Засгийг нээлттэй болгосон уу?						
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Ихэнх нь	Бүрэн	Ихэнх нь	Бүрэн	Ихэнх нь	Бүрэн	Ихэнх нь	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой	
3.3.1.3: Төсвийн ил тод байдлыг хангах				✓	✓			✓	✓			✓			✓						✓	
3.3.1.7: Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг ил тод болгох				✓	✓							✓		✓					✓			
3.3.1.8: Төсвийн хөрөнгө оруулалттай 80 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авахжиллагааны гэрээг ил тод болгох				✓	✓						✓				✓				✓			

Зорилго

Энэ бүлгийн зорилтууд нь төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад чиглэсэн болно. Төсвийн бүрдүүлэлт, орлого, зарлага, худалдан авалт, хөрөнгө оруулалтын мэдээллээр хангах (3.3.1.3), гадаадын зээл тусламжийн төсөл, хөтөлбөрийн мэдээллийг ил тод болгох (3.3.1.7), 80 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авах ажиллагааны гэрээг ил тод болгох (3.3.1.8).

Хэрэгжсэн байдал

Зорилт 3.3.1.3

Дунд хугацаанд: Ихэнх нь

2014 оны 7 дугаар сарын 1-нд УИХ-аас батлан гаргасан Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжиж байна. Үүгээр Монгол Улсын төрийн болон төсвийн бүх байгууллага, төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа хуулийн этгээдүүд төсвийн үндсэн мэдээллээ нээлттэй болгохыг заасан юм. Тухайлбал, төсвийн байгууллагууд нийт 28 нэр төрлийн мэдээлэл, үүнээс 13 нэр төрлийн мэдээллийг батлагдсан маягтаар төсвийн гүйцэтгэлийн жил, улирал, сар тутмаар Шилэн дансны цахим хуудсаар www.shilendans.gov.mn дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Цалингаас бусад 5 саяас

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

дээш төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг шийдвэр гарсанаас хойш 7 хоногийн дотор тайлагнана.

Уг системийн талаар 2 удаа 2014 оны 1-р сар, 2015 оны 5-р сард зөвлөлдөх уулзалт болсон. 2 дахь уулзалтыг Ерөнхийлөгчийн Тамгын Газар (ЕТГ) Үндэсний Аудитын Газар, Сангийн Яам, Нээлттэй Нийгэм Форумтай хамтран 2015 оны 5-р сарын 15-нд “Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх нь” сэдвээр Засгийн газрын ордонд зохион байгуулсан. Мөн Засгийн газар Шилэн дансны тухай хуулиар 82 удаагийн сургалтыг 10000 төрийн албан хаагчдад зориулан зохион байгуулсан гэж мэдээлэв.¹ Шилэн дансны цахим хуудас ажиллаж эхэлсэн учраас ХБТ-ын судлаачид дунд хугацаанд энэхүү зорилтын ихэнх хэсэг нь биелсэн гэж үзэж байна.

Эцсийн хугацаанд: Ихэнх нь

Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn 2015 оноос ажиллаж эхэлсэн бөгөөд төсөв, санхүү, худалдан авалтын мэдээллийг агуулдаг. Уг цахим хуудсанд 4966 төсвийн байгууллага, 84 төслийн нэгж, засгийн газрын болон орон нутгийн 73 тусгай сан, 510 төрийн өмчийн үйлдвэр газар мэдээллээ байршуулсан байна.² Засгийн газрын өөрийн үнэлгээний тайланд 2015 оны 9-р сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хуулийн дагуу мэдээллээ оруулаагүй албан тушаалтануудад хариуцлага тооцсон тухай дурдсан боловч чухам ямар хариуцлага тооцсон нь тодорхойгүй байна.³ Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн мэдээгээр Шилэн дансны хуулийг зөрчсөн үндэслэлээр ямар нэг хэрэг бүртгэгдээгүй болно. Засгийн газрын өөрийн үнэлгээний тайланд дурдсанаар 15000 орчим албан хаагчдад 112 удаагийн сургалт зохиосон байна.⁴

Хэдийгээр одоо энэ цахим хуудас хэдэн мянган байгууллагын төсвийн мэдээллийг агуулж байгаа боловч 6 дэд зорилтоос 4 нь хэрэгжээгүй байгаа тул бүрэн хэрэгжсэн гэж үзэхэд учир дутагдалтай байна. Эдгээр нь төсвийн байгууллагын албан хаагчдад төсвөөс үзүүлсэн дэмжлэгийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд нээлттэй байлгах, төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн болон хийгдэж байгаа төслүүдийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн байгууллагад хувь хүн, байгууллагаас өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх, орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдлыг хангах, иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулж ажиллуулах зэрэг юм.

Зорилт 3.3.1.7

Дунд хугацаанд: Ихэнх нь

Өмнө нь гадаадын зээл тусламжийн мэдээллийг төрийн зүгээс албан ёсоор олон нийтэд ил тод, нээлттэй болгох тогтолцоо алга байна. Харин 2015 оны 2 дугаар сарын 18-нд Монгол Улсад анх удаа Өрийн удирдлагын тухай хууль батлагдсан. Сангийн яамны Өрийн удирдлагын газрын дарга ХБТ-ын судлаачидтай хийсэн ярилцлагынхаа үеэр уг хуулийн хэрэгжилтийн хүрээнд 1992 оноос хойш Монгол Улсын Засгийн газрын авсан зээл, төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хүрээнд хийгдсэн ажлын тухай мэдээллийг багтаасан мэдээллийн сангийн системийг боловсруулж дуусч байгаа ба барагцаалбал хагас жилийн турш мэдээлэл оруулж бүрдүүлсний дараа нийтэд ил тод болгохоор төлөвлөсөн гэж мэдээлэв. Уг албан тушаалтан энэхүү зорилтыг бараг хэрэгжсэн гэж үзэж байв.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Эцсийн хугацаанд: Ихэнх нь

Засгийн газрын зүгээс гадаадын зээл тусламжийн төсөл, хөтөлбөрийн мэдээллийг ил тод болгох талаар эхний томоохон алхамыг хийж Сангийн Яам <http://odamis.mof.gov.mn> цахим хуудсыг ажиллуулж эхэлсэн. 2016 оны дунд үеийн байдлаар тус цахим хуудсанд хэрэгжиж дууссан болон одоо хэрэгжиж буй нийт 1000 орчим төсөл, хөтөлбөрийн санхүүжүүлэгч, зардал, үйл ажиллагааны талаар мэдээлэл орсон байна. Гэвч зорилтод заасны дагуу зээлийн хүүгийн түвшин, эргэн төлөгдөх нөхцөл зэрэг санхүүгийн тодорхой мэдээлэл, хэрэгжүүлэгч байгууллагын нэр зэрэг нь ороогүй байна.

Зорилт 3.3.1.8

Дунд хугацаанд: Ихэнх нь

2014 оны 7 дугаар сарын 1-нд УИХ-аас батласан Шилэн дансны тухай хуулийн дагуу 5 сая төгрөгөөс илүү дүнтэй төсвийн хөрөнгөөр хийсэн худалдан авах ажиллагааны мэдээллийг ил тод болгох ёстой. Засгийн газрын дунд хугацааны өөрийн үнэлгээний тайланд худалдан авалтын үйл ажиллагааны мэдээлэл бүрэн ил тод болоогүй учраас энэхүү зорилтыг биелээгүй гэж үзсэн байна.⁵

Эцсийн хугацаанд: Ихэнх нь

2016 оны 1-р сарын 1-нээс эхлэн Засгийн газар Шилэн дансны хуулийн дагуу 5 саяас дээш үнийн дүнтэй худалдан авалтын гэрээг ил тод болгох ёстой. Засгийн газар худалдан авалтын тендер, гэрээний үнийн дүн, тендерт оролцогчид болон тендерийн үр дүнг www.tender.gov.mn цахим хуудсанд тавьж байгаа болно. Уг цахим хуудаснаас тендерийн ангилал, нэр, төсвийн захиран зарцуулагч, он, бүс нутгаар нь дата визуаль аргаар болон ангилан үзэж болно. Засгийн газрын өөрийн үнэлгээний эцсийн тайлангийн дагуу 10 000 орчим тендер, түүний үр дүнг байршуулсан байна.⁶ Гэвч зорилтод заасны дагуу тендерийн гэрээг ил тод болгох ажил хийгдээгүй байна. Мөн Засгийн газар олон тооны тендерийн үр дүнгийн мэдээлэл тавигдаагүй байгааг хүлээн зөвшөөрсөн болно.⁷

Засгийг нээлттэй болгосон уу?

Зорилт 3.3.1.3

Мэдээллийн хүртээмж: Томоохон

Төрийн хариуцлагатай байдал: Өөрчлөгдөөгүй

Нээлттэй Нийгэм Форум болон бусад ИНБ-ууд төсөв, санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэхийн төлөө олон жил ажиллаж байна. Шилэн дансны хууль батлагдахын өмнө төсвийн ил тод байдлын шаардлагууд цэгцгүй, хэрэгжилт нь үр дүн муутай байсан. Нээлттэй Төсвийн Судалгааны дагуу Монголын засгийн газар олон нийтэд төсвийн талаар хязгаарлагдмал мэдээлэл өгч байв.⁸ Энэ утгаараа уг зорилт нь томоохон үр нөлөө үзүүлэх боломжтой байлаа.

ҮАҮТ-ний хэрэгжилтийн хугацааны төгсгөлд энэхүү зорилт нь мэдээллийн хүртээмжийн чиглэлд том хувь нэмэр оруулсан байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Үндэсний Аудитын Газрын шалгалтанд 5804 төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

хамрагдсаны 96,8 хувь буюу 5617 нь төсвийн ерөнхий мэдээллээ байршуулсан байв.⁹ Мөн 2015 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн засаг захиргааны байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 98 хувьтай байна гэж нийслэлийн Дотоод аудитын газраас танилцуулсан болно.¹⁰

Нээлттэй Нийгэм Форум ИНБ-уудтай хамтран 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийг хамарсан 52 орон нутгийн ЗДТГ-т Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд мониторингийн судалгаа хийсэн болно. Судалгаагаар худалдан авалт, орлого, зарлага, холбогдох мэдээлэл, шийдвэрийн талаар ил тод болгосон мэдээлэл 2015 оны 1-р улирлыг 2-р улиралтай харьцуулахад 74%-иар өсчээ.¹¹ Гэвч Ил Тод Байдал Сангийн Ц.Отгонсүрэнгийн үзэж байгаагаар худалдан авалтын шийдвэр, гэрээ зэрэг мэдээлэл ил тод болоогүй байна.

Төрийн хариуцлагатай байдлын хувьд ҮАҮТ хэрэгжиж дуусахад иргэдийн хяналтын тогтолцоо бий болоогүй байна. Төсвийн мэдээллийг ил тод болгож байгаа боловч үүнээсүүдэн гарсан үр дүн, өөрчлөлтийг иргэдэд хэрхэн хүргэх сувгийг бий болгоогүй. Ийм учраас төрийн хариуцлагын хувьд өөрчлөлт гараагүй болно.

Зорилт 3.3.1.7

Мэдээллийн хүртээмж: Бага зэрэг

Өмнө нь гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн болон хэрэгжиж буй төслүүдийн талаар мэдээлэл дутмаг байв. “Иргэд төсвөө хянана” сүлжээний үзэж байгаагаар зээл, тусламжийн бүртгэл, хяналт ихэнхдээ хангалтгүй, төслүүдийн мэдээлэл олддоггүй байсан.¹² Хөгжлийн Банкны авсан зээл, гаргасан засгийн газрын бондууд нь төсвөөс гадуур бүртгэгдэж байсан нь иргэдэд хянах боломж олгохгүй байлаа. Тийм учраас энэхүү гадаадын зээл тусламжийн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээллийг ил тод болгох зорилт нь дорвитой үр нөлөө авчрах боломжтой байв.

Энэ зорилт хэрэгжсэний үр дүнд мэдээллийн хүртээмж сайжирлаа.

<http://odamis.mof.gov.mn> шинэ цахим хуудсанд 1000 орчим төсөл, хөтөлбөрийн санхүүжүүлэгч нэр, нийт төсөв зэрэг өмнө ил тод бус байсан мэдээлэл орсон байна. Гэвч зээлийн хүүгийн түвшин, эргэн төлөгдөх нөхцөл, хэрэгжүүлэгч байгууллагын нэр зэрэг мэдээлэл тавигдах нь иргэдэд зээл бүрийн үр ашгийг хянан шалгах боломжийг бүрдүүлнэ.

Зорилт 3.3.1.7

Мэдээллийн хүртээмж: Бага зэрэг

Мэдээллийн хүртээмжийн хувьд 5 саяас дээш төгрөгийн худалдан авалтын мэдээллийг иргэд www.tender.gov.mn цахим хуудаснаас олж авах боломжтой болсон. Өмнө нь худалдан авалтын мэдээлэл ил тод бус байсан тул энэ нь эхний чухал алхам болж байна. Гэвч засгийн газрын тайлагнаснаар, 2016 онд 3000 шахам тендерийн зар тавигдсан ч зөвхөн 567 тендерийн үр дүнг зарласан байна. Засгийн газар харьяа байгууллагууд нь тендерийн үр дүнг олон нийтэд ил болгох тал дээр хангалтгүй ажилласныг хүлээн зөвшөөрсөн болно. Олон нийтийн зүгээс төрийн байгууллагууд 5 саяас төгрөгөөс дээш худалдан авалтаа нуухын тулд зардлаа хувааж байна гэсэн хардлага байдаг. Үүнийг шийдэхийн тулд дараагийн ҮАҮТ-нд худалдан авалтыг ил тод болгох босгыг 1 сая төгрөг болгох зорилт оруулсан.¹³

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Дараагийн ҮАҮТ-нд орсон эсэх

Шилэн дансны цахим хуудасны талаар дараагийн ҮАҮТ-нд оруулсан. Засгийн газар иргэд, иргэний нийгмийн зүгээс гарсан асуулт, саналыг онлайн хэлбэрээр хүлээн авах механизмыг бүрдүүлэхээр ажиллана. Мөн шинэ ҮАҮТ-нд 1 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй төсвийн худалдан авалтыг ил тод болгох, гадаадын зээл тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилтууд орсон болно.

¹ ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний дундын тайлан 2015. <http://bit.ly/2tfajWK>

² Сангийн Яам. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт. 2016.11.03 <http://bit.ly/2oO6Ooe>

³ ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний дундын тайлан 2015. <http://bit.ly/2tfajWK>

⁴ ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016. (НЗТ. 2016) <http://bit.ly/2tnPaYS>

⁵ ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний дундын тайлан 2015. <http://bit.ly/2tfajWK>

⁶ ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016. (Нээлттэй Засаг Түншлэл. 2016) <http://bit.ly/2tnPaYS>

⁷ Монгол улсын ҮАҮТ-II, 2016-2018. (НЗТ.2016) <http://bit.ly/2tM0v7d>

⁸ *Mongolia Open Budget Survey Document Availability Tracker*, (International Budget Partnership, Dec. 2016) <http://bit.ly/2IAjzr>

⁹ Үндэсний Аудитын Газар. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа” (2015.05.15) <http://www.audit.mn/?p=2736>

¹⁰ News.mn. “Шилэн дансны хуулийг 98%-тай хэрэгжүүлж байна” (2015.08.28) <https://www.news.mn/r/220789>

¹¹ ННФ-с хийсэн мониторингийн судалгаа <http://bit.ly/2p93QeC>

¹² www.tusuv.mn –г үзнэ үү

¹³ Монгол улсын ҮАҮТ-II, 2016-2018. (НЗТ.2016) <http://bit.ly/2tM0v7d>

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

3-р бүлэг: Байгалийн нөөц баялгийн ашиглалтын ил тод байдал

3.3.1.4: Ашигт малтмал, газрын тос, газар, ус зэрэг нийтийн өмчийг ашиглахаар байгуулж байгаа гэрээний ил тод байдлыг хангах. Ашигт малтмал, газрын тосны болон газар эзэмших тусгай зөвшөөрлийг ил тод болгох.

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

3.3.1.5: Ашигт малтмал, газрын тос, газар, ус зэрэг нийтийн өмчийг ашиглах бүх төрлийн гэрээ буюу бүтээгдэхүүн хуваах, тогтвортой байдал болон хөрөнгө оруулалтын гэрээний ил тод байдлыг хангах.

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

3.3.1.6: Байгаль орчны ил тод байх ёстой мэдээллийн жагсаалт гаргаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хор хохирол учруулахуйц үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох.

Компани болон хуулийн этгээдийн жагсаалтыг ил тод болгох.

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

Хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ, УУЯ, АМГ, БОНХАЖЯ, ТББ

Хамтран ажиллах байгууллага: Тодорхойлоогүй

Редакцийн тэмдэглэл: ХБТ-ын судлаачид байгалийн баялгийн ашиглалтын ил тод байдал, мэдээллийн хүртээмжийн бүлэгт эдгээр зорилтуудыг сонгон авч, дүн шижилгээ хийлээ.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэт гэл		Хунд хугацааны: Эцсийн		Засгийг нээлттэй болгосон уу?					
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Ихэнх нь	Бүрэн	Ихэнх нь	Бүрэн	Ихэнх нь	Бүрэн	Ихэнх нь	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой	
3.3.1.4: Ашигт малтмал, газрын тос, болон тусгай зөвшөөрлийн ил тод байдал			✓		✓							✓		✓					✓			
3.3.1.5: Ашигт малтмал, газрын тос, газар, ус ашиглах гэрээний ил тод байдал				✓	✓							✓		✓					✓			
3.3.1.6: Байгаль орчны талаарх мэдээллийн ил тод байдал				✓	✓							✓			✓						✓	

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилго

Энэ бүлгийн зорилтууд нь байгалийн нөөц баялгийн салбарын ил тод байдлыг сайжруулахад төвлөрсөн болно. Үүнд: ашигт малтмал, газрын тос, газар эзэмшлийн тусгай зөвшөөрлийн нэгдсэн мэдээллийн сан бий болгох (3.3.1.4), ашигт малтмал, газрын тос, газар, ус зэрэг нийтийн өмчийг ашиглах бүх төрлийн гэрээ буюу бүтээгдэхүүн хуваах, тогтвортой байдал болон хөрөнгө оруулалтын гэрээний ил тод байдлыг хангах (3.3.1.5) байгаль орчин, хүний эрүүл мэндэд хор хохирол учруулахуйц үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох (3.3.1.6) зэрэг зорилтууд орсон.

Хэрэгжсэн байдал

Зорилт 3.3.1.4

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

Тайлант хугацааны эхний жилд Монгол улсад ашигт малтмал, газрын тос, үл хөдлөх хөрөнгийг эзэмших зөвшөөрлийн тухай нэгдсэн мэдээллийн сан байхгүй, төрийн байгууллагууд тус тусдаа эдгээр мэдээллийг хариуцан гаргадаг байв. Жишээлбэл: Ашигт малтмалын газар ашигт малтмалын лиценз, бүртгэлийн асуудлыг хариуцах ба <http://cmcs.mram.gov.mn/cmcs#cid=1> цахим хаягт лицензийн тухай мэдээллийг байршуулдаг. Харин Газрын тосны газар газрын тосны лицензтэй холбоотой асуудлыг хариуцдаг.

Одоогоор Ашигт малтмалын газар Үндэсний Дата төвтэй хамтран тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийн санг цахим өгөгдлийн сангийн хэлбэрт оруулахаар ажиллаж байна. 2014 онд Дэлхийн банкны “Засаглалыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Уул уурхайн кадастрын компьютержсэн систем” /УУККС/ төслийг АМГ-т хэрэгжүүлсэн нь мэдээллийн нэгдсэн сан байгуулах чиглэлээр хийгдэж буй чухал алхам болсон. Гэвч үр дүн нь олон нийтэд тодорхой харагдахгүй байгаа тул уг зорилтын хэрэгжилтийг хязгаарлагдмал гэж үнэлсэн болно.

Эцсийн хугацаанд: Хязгаарлагдмал

Тайлант хугацааны сүүлийн жилд тусгай зөвшөөрлийн нэгдсэн мэдээллийн сан бий болоогүй, байгууллагууд тус тусдаа мэдээллээ хариуцан гаргасан хэвээр байлаа. Жишээ нь, <https://cmcs.mram.gov.mn/cmcs> цахим хуудаснаас хүчинтэй тусгай зөвшөөрлийн жагсаалт, товч мэдээлэл, байршил зэргийг үзэж болно. Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар (АМХЭГ) шинээр лиценз эзэмшигчдийн сонгон шалгаруулалт, лиценз эзэмшилтийн шилжилтийн мэдээллийг өөрийн энэ цахим хуудсанд байнга тавьдаг. Ашигт малтмалын лиценз эзэмшлийн мэдээллийг мөн Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачлагын (ОУИТБС) цахим хуудаснаас авч болно.¹ Газрын тосны лицензийн хувьд олборлотын үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын мэдээлэл, бүтээгдэхүүн хуваах гэрээ зэргийг Газрын Тосны Газрын цахим хуудаснаас үзэж болно.² Гэвч эдгээр мэдээлэл 2016 онд шинэчлэгдээгүй байна. Эцэст нь, аймаг, хотын газрын албад газрын лиценз эзэмшигчдийн мэдээллийг ил тод болгоогүй байна.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилт 3.3.1.5

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

Зарим гадаадын хөрөнгө оруулалттай, тогтвортой байдлын томоохон гэрээнүүд нээлттэй болсон. Тухайлбал, олон нийтийн анхаарлыг хамгийн их татсан Оюутолгойн хөрөнгө оруулалт, тогтвортой байдлын гэрээ 2014 онд олон нийтэд нээлттэй болсон.³ Харин бусад гэрээнүүд тухайлбал газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд компанийн бизнесийн нууцтай холбоотой гэх шалтгаанаар хаалттай хэвээр байна. 2014 онд батлагдсан Газрын тосны тухай хуулийн (шинэчилсэн найруулга) 8 дугаар бүлгийн 36.1-д гэрээлэгч нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, ... төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх үүрэгтэй. Харамсалтай нь уг хуулийн заалт тайлант хугацааны эхний жилд хэрэгжиж эхлээгүй байв.

Эцсийн хугацаанд: Хязгаарлагдмал

Төрийн эзэмшлийн нөөц баялагтай холбоотой гэрээнүүдийг ил тод болгох тал дээр тодорхой ахиц дэвшил гараагүй. Засгийн газрын байгуулсан бүтээгдэхүүн хуваах 25 гэрээний 3 нь л олон нийтэд нээлттэй байна.⁴ Харин ОУИТБС-ын хүрээнд нутгийн захирагааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд байгуулсан 25 гэрээг нийтэлсэн болно.⁵ Иргэний нийгэм, засгийн газар хоорондын яриа хэлэлцээний үр дүнд, Нээлттэй Нийгэм Форум, ОУИТБС-ын ажлын алба, Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамтай хамтран бүтээгдэхүүн хуваах гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ, концесс, уул уурхайн орон нутгийн хөгжлийн гэрээ, хуучин тогтвортой байдлын гэрээнүүдийг багтаасан мэдээллийн санг бий болгосон байна.⁶ Гэвч, 2017 оны 3-р сарын байдлаар энэхүү мэдээлийн санд 7 гэрээг л байршуулсан байна. Мөн Засгийн газар ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн 2015 оны 5-р сард гарын үсэг зурсан Оюутолгойн гэрээний нэмэлтийг www.zasag.mn хуудсандаа тавьсан болно.

Зорилт 3.3.1.6

Дунд хугацаанд: Ихэнх нь

Байгаль орчны мэдээллийн ил тод байдал хувьд нилээд ахицтай байв. БОНХЯ-ны сайд 2014 оныг “Байгаль орчны мэдээллийн ил тод байдлын жил” болгож зарласнаар энэ асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулсан.⁷ 2014 оны 3-р сард Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын тушаалаар Байгаль орчны мэдээллийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн ба ажиллах журмыг шинэчлэн баталсан. Мөн оны 9-р сард албан даалгавар гаргаж байгаль орчны талаарх мэдээлэл хангалттай бус байгаа тул мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны болон аймаг, нийслэлийн төр, захиргааны байгууллагууд өөрт хамаарах мэдээллийг бүрэн бүрдүүлж, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санд (www.eic.mn) цахим хэлбэрээр төвлөрүүлэх үүрэг хүлээлгэсэн юм. Уг цахим мэдээллийн нэгдсэн сан 22 дэд сангийн мэдээллээс бүрдэх ба үүнд зорилтод дурдсанчлан агаарын бохирдлын тухай мэдээлэл багтаж байна. Хэдийгээр

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

судлаачид зорилтын компани болон хуулийн этгээдийг ил тод болгох зорилтын хоёр дахь хэсгийн талаар илүү тодорхой мэдээлэл олж авч чадаагүй ч энэхүү зорилтыг үндсэндээ биелсэн гэж үзлээ.

Эцсийн хугацаанд: Ихэнх нь

2017 оны эхэн үеийн байдлаар www.eic.mn нэгдсэн мэдээллийн санд 29 бүлэг мэдээлэл орсон байна. Мөн Засгийн газар www.agaar.mn цахим хуудсаар агаарын чанар, хууль тогтоомж, бусад холбогдох мэдээллийг иргэдэд өгч байна. Мөн энэхүү сайт нь гар утасны аппликэшн хэлбэрээр байдаг бөгөөд хэргэлэгчид Улаанбаатар хотын янз бүрийн цэгт агаарын бохирдол ямар байгааг шалгаж болдог.⁸

ННФ-ийн дэмжлэгтэй хэрэгждэг “Иргэдийн байгаль орчны мэдээлэл авах эрх” төслийн хүрээнд ИНБ-ууд болон төрийн байгууллагууд хамтран байгаль орчны мэдээллийг илүү нээлттэй болгох талаар ажиллаж байна. Гэвч зорилтод заасны дагуу байгаль орчинд хор хөнөөлтэй үйл ажиллагаа явуулж буй компани, хуулийн этгээдүүдийн жагсаалтыг ил тод болгох ажил одоогоор хийгдээгүй байна. Тийм учраас энэ зорилтын ихэнх хэсэг нь хэрэгжсэн гэж дүгнэж байна.

Засгийг нээлттэй болгосон уу?

Зорилт 3.3.1.4

Мэдээлийн хүртээмж: Бага зэрэг

2014 онд хийсэн судалгаагаар Монголд газрын алба, ашигт малтмал, орон нутгийн худалдан авалт хариуцсан байгууллагууд хамгийн их авилгад өртдөг гэсэн үр дүн гарсан.⁹ 2010 оноос шинээр лиценз олголтонд хориг тавьсан байсан нь 2015 оны 1-р сарын 1-нээс цуцлагдаж, олголт эхэлсэн нь авилга, шударга бус давуу эрхийн байдал үүсгэж байж болзошгүй гэсэн хардлагыг дагуулах болсон.¹⁰ Тийм учраас газрын тос, ашигт малтмал, газар эзэмшлийн лиценз эзэмшигчдийн нэгдсэн мэдээллийн сан бий болгох нь томоохон үр нөлөөтэй байв.

Гэвч энэхүү зорилт нь бүрэн биелээгүй. Хэдийгээр ашигт малтмалын лиценз эзэмшигчдийн мэдээлэл интернетэд тавигдсан байгаа ч газрын тос, газар эзэмшигчдийн мэдлээлэл хязгаарлагдмал байна. Засгийн газар 2015 онд газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 15 компаний мэдээллийг ил тод болгосон ч 2016 онд үүнийгээ шинэчлээгүй байна.¹¹ Иргэний нийгэм үүнийг хангалтгүй гэж үзэж байгаа бөгөөд лиценз эзэмшигч компаниудын ашиг хүртэгч эздийн мэдээллийг Мэдээлийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулийн дагуу нээлттэй болгохыг шаардаж байна.¹²

Зорилт 3.3.1.5

Мэдээлийн хүртээмж: Бага зэрэг

Монголд олборлох салбарын эргэн тойронд болдог бодлогын хэлэлцүүлгүүдийн гол сэдэв нь ихэвчлэн гэрээний асуудал байдаг. Өмнө нь хяналт тавьдаг ИНБ-уудад гэрээний талаарх мэдээлэл хаалттай байв.¹³ Тийм учраас бүх хөрөнгө оруулалт, тогтвортой байдал, бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод болгох зорилт томоохон өөрчлөлт авчрах боломжтой байлаа. Гэвч энэ зорилтын хэрэгжилт нь хангалтгүй байна. Ихэнх бүтээгдэхүүн хуваах гэрээ олон нийтэд хаалттай хэвээр

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

байна. Гэвч гэрээний мэдээлийн сан болох www.iltodgeree.mn цахим хуудас нээгдсэн нь эхний чухал алхам боллоо. 2017 оны эхний байдлаар 7 гэрээ pdf форматаар тавигдсан байна. Хэрэглэгчид гэрээнүүдийг хайх, харьцуулах, татаж авах боломжоор хангагдсан байна.¹⁴

ОУИТБС-ын хүрээнд орон нутаг, уул уурхайн компаниудын хоорондын гэрээ ил тод болж 25 гэрээ интернетэд тавигдсан байна.¹⁵ Мөн 2006 оноос хойш аж ахуйн нэгжүүд байгалийн нөөц ашиглалтын лиценз авахдаа орон нутгийн удирдлагатай зөвшилцөх шаардлагатай болсон. Хэдийгээр энэхүү шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа ч¹⁶ зарим нэг нааштай үр дүн гарч байна. Жишээ нь, Нийслэлийн Байгаль орчны газрын мэдээлсэнээр Хан-Уул дүүрэгт 38 лиценз авах хүсэлтэд ИТХ нь иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр татгалзсан хариу өгсөн байна.

Зорилт 3.3.1.6

Мэдээлийн хүртээмж: Томоохон

Засгийн газар байгаль орчны холбогдолтой мэдээлийн ил тод байдлын талаар чухал алхам хийсэн. Мэдээлийн нэгдсэн сан www.eic.mn –д 29 бүлэг мэдээлэл орсон байна. Хэдийгээр эдгээр мэдээллийг байгаль орчны холбогдолтой хууль, тогтоомжуудын дагуу заавал байршуулах шаардлагатай хэдий ч ихэнх мэдээлэл нь хуучирсан байна. Жишээ нь газар болон хөрстэй холбоотой сүүлийн мэдээлэл нь 2014 оных байна.

Хамгийн үр нөлөөтэй ажил нь агаарын чанарыг тодорхойлдог www.agaar.mn цахим хуудас болж байна. Агаарын бохирдол бол Монголын хувьд хамгийн сэтгэл түгшээсэн асуудлуудын нэг юм. 2011 онд Канадын Саймон Фрээр Их Сургуулийн хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын оршин суугчид дундах нас баралтын 10% нь ямар нэг байдлаар агаарын бохирдолтой холбоотой байна.¹⁷ 2016 оны сүүлч, 2017 оны эхээр агаарын бохирдлын эсрэг олон мянган хүнийг хамарсан жагсаал, цуглаанууд болсон.¹⁸

www.agaar.mn цахим хуудаснаас иргэд эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл, агаарын бохирдолыг хэд хэдэн үзүүлэлтээр, судалгаа, мэдээлэл зэргийг авч болно. Мөн энэ сайт нь гар утасны аппликэшн-тэй. Earth Journalism Network www.agaar.mn цахим хуудас нь сүүлийн жилүүдэд Монголд агаарын чанарын хяналт ихээхэн сайжирсаны нэг жишээ юм гэж бичжээ.¹⁹

Энэ цахим хуудсанд 2017 оны 3-р сарын байдлаар ойролцоогоор 120 000 хандалт хийгдсэн байна.²⁰ Мөн 2016 оны 12-р сард мэдээлийн олон хэрэгслүүд Улаанбаатар хотод агаарын чанар ДЭМБ-ын санал болгодог зохих түвшний үзүүлэлтээс 80 дахин муудаад байгааг мэдээлж байсан.²¹

Дараагийн ҮАҮТ-нд орсон уу?

Энэ бүлгийн эхний хоёр зорилт дараагийн ҮАҮТ-нд орсон. Лиценз эзэмшлийн тухайд, Засгийн газар уул уурхайн салбарт ашиг хүртэгч эзэмшигчдийг ил тод болгохыг зорино. Гэрээний тухайд, Засгийн газар эхэлж ил тод болгох нийтийн өмч, гэрээний хэлбэрүүдийг тогтоож, дараа нь гэрээнүүдийг мэдээлийн санд ил тод байршуулах болно.

¹ ОУИТБС-ын цахим тайлангийн систем, <http://tailan.eitimongolia.mn/>

² Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр газрын тосны олборлолт, хайгуул хийж буй компаниуд (Газрын Тосны Газар, 2015.01.№%), <http://bit.ly/2lx2dSt>

³ Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ. <http://ot.mn/investment-agreement/?eoi>

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

-
- ⁴ Газрын тосны бүтээгдэхүүн хуваах 3 гэрээ Open Oil Repository-д тавигдсан байна. Энэ 3 мөн дээр нь 4 гэрээ Resource Contracts цахим хуудсанд байна. <http://repository.openoil.net/wiki/Mongolia> , <http://www.resourcecontracts.org/countries/mn>
- ⁵ Гэрээ (Монголын ОУИТБС, 2016), <http://eitimongolia.mn/mn/contracts>
- ⁶ Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан <http://www.iltodgeree.mn/page/9/detail>
- ⁷ Л.Дэлгэр. “Байгаль орчны мэдээллийг ил тод болгоно” (Eagle. 2014.02.05) <http://old.eagle.mn/content/read/12412.htm>
- ⁸ “Агаар.mn,” (Itunes Preview, 2014.05.28), <https://itunes.apple.com/us/app/agaar-mn/id911239950?mt=8>
- ⁹ Азийн сан, Сантмарал сан. *Авлигын талаарх олон нийтийн ойлголт болон мэдлэг тогтох судалгаа.* (2014.06), <https://asiafoundation.org/resources/pdfs/SPEAKIVEnglishJune2014.pdf>
- ¹⁰ Terrence Edwards, “Whiff of corruption hangs over Mongolia’s mining license auctions,” (Intellinews, 17 Mar. 2015), <http://bit.ly/1NXMBhS>
- ¹¹ Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр газрын тосны олборлолт, хайгуул хийж буй компаниуд (Газрын Тосны Газар, 2015.01.№%), <http://bit.ly/2lx2dSt>
- ¹² Н.Дорждарь (Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэнгийн Монголыг хариуцсан менежер). ХБТ-ын судлаачдад өгсөн тайлбар
- ¹³ Dorjdari Namkhajantsan, “Contract Transparency a Critical Component of Civil Society Oversight in Mongolia,” (Natural Resource Governance Institute, 19 Nov. 2015), <http://bit.ly/2m3TKrN>
- ¹⁴ Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан <http://www.iltodgeree.mn>
- ¹⁵ Гэрээ (Монголын ОУИТБС, 2016), <http://eitimongolia.mn/mn/contracts>
- ¹⁶ Vyambajav Dalaibuyan, “Enhancing transparency of local level agreements in the Mongolian mining industry,” (GOXI, 2 Dec. 2015), <http://goxi.org/profiles/blogs/mongolia-s-model-cda-intent-and-limitations>
- ¹⁷ “Study: Air pollution killing Ulaanbaatar (Mongolia) residents,” (Simon Fraser Univ., 16 Aug. 2011), <http://bit.ly/2mX05VJ>
- ¹⁸ Grace Brown, “In frigid cold, Mongolians stand in protest of air pollution,” (Associated Press, 28 Jan. 2017), <http://wapo.st/2mtAS7F>
- ¹⁹ Peter Bittner, “Clearing the air: Why Mongolia’s ‘Ger’ districts are key to solving its air pollution crisis,” (Earth Journalism Network, 18 Mar. 2016), <http://bit.ly/2hKoY7E>
- ²⁰ Агаар.mn, 2017.03.02 байдлаар, <http://agaar.mn/index>
- ²¹ Michael Kohn, “World’s Worst Air Has Mongolians Seeing Red, Planning Action,” (Bloomberg, 22 Dec. 2016), <http://bloom.bg/2i6WTV7> . See also Oyungerel Munkhbat, “Putting a magnifying glass on air pollution,” (The UB Post, 12 Jan. 2017), <http://theubpost.mn/2017/01/12/putting-a-magnifying-glass-on-air-pollution/>

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

4-р бүлэг: Иргэний оролцоог нэмэгдүүлэх

3.3.2.1: Төрийн үйлчилгээг сайжруулахад иргэдийн оролцоог хангах

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

3.3.2.6: Засгийн газрын “11-11” иргэдийн санал гомдлын төвд хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулахад тусгадаг болгох.Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

3.3.3.5: Иргэдийн ашиг сонирхолтой зөрчилдсөн, иргэдийн оролцоогүйгээр гарсан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох журам гаргах

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

3.3.3.7: Зорилтот бүлгүүдэд чиглэсэн эрх зүйн боловсрол олгох

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

Хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ, ХЗЯ, Бүх яам, Аймаг, сумын Засаг дарга, МТШХХГ, Нийслэл, дүүргийн Засаг дарга

Хамтран ажиллах байгууллага: Тодорхойлоогүй

Редакцийн тэмдэглэл: ХБТ судлаачид эдгээр зорилтууд нь иргэний оролцооны сэдвийг хөндөж байгаа тул нэг бүлэгт оруулсан. 3.3.2.6 зорилтын ТҮЦ машины тухай хэсэг нь 3.3.2.5-тай давхцаж байгаа тул 5-р бүлэгт оруулан үнэлсэн болно.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал			Нөлөө				Гүйцэтгэл		Хунд хугацааны:	Засгийг нээлттэй болгосон уу?							
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээлэлтийн	Иргэний оролцоо	Нийгмийн хариуцлагатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой	
3.3.2.1: Төрийн үйлчилгээг сайжруулахад иргэдийн оролцоог хангах			✓			✓	✓			✓			✓						✓			
3.3.2.6: Засгийн газрын “11-11” иргэдийн санал гомдлын төвд хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулахад				✓	✓	✓	✓			✓					✓			✓				

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

тусгадаг болгох																				
3.3.3.5: Иргэдийн ашиг сонирхолтой зөрчилдсөн, иргэдийн оролцоогүйгээр гарсан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох журам гаргах			✓			✓	✓					✓								✓
3.3.3.7: Зорилтот бүлгүүдэд чиглэсэн эрх зүйн боловсрол олгох		✓				✓	✓					✓								✓

Зорилго

Энэ бүлгийн зорилтууд иргэд болон төрийн хооронд мэдээлийн сувгийг бий болгох (3.3.2.1), иргэдийн гомдол, саналыг хүлээн авдаг мэдээллийн систем (3.3.2.6), иргэдийн оролцоогүйгээр гарсан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох журам гаргах (3.3.3.5) иргэдийн чадавхийг бэхжүүлэх (3.3.3.7) зэргээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн болно.

Хэрэгжилт

Зорилт 3.3.2.1

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

Төрийн байгууллагаас гаргаж буй аливаа шийдвэрийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангахад зарим ахиц гарч байна. “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-д “шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах” гэсэн заалт бий.¹

Эцсийн хугацаанд: Ихэнх нь

2015 оны 7-р сарын 8-нд УИХ-с “Нийтийн сонсголын тухай” хуулийг батлан гаргасан нь бодлогын шийдвэрийн төслүүд дээр олон нийтийн сонсгол явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх чухал алхам болсон юм. Хуулийн хамрах хүрээнд төрийн захиргааны төв байгууллагуудаас гадна орон нутгийн төр, захиргааны байгууллага багтаж байна. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг парламент баталснаар иргэний нийгмийн байгууллагууд бодлогыг томъёолж хяналт тавих эрх зүйн боломжийг бүрдүүлэв. Захиргааны ерөнхий хуулиар иргэдийн саналыг сонсох, хэлэлцүүлэх, зохион байгуулах бол Хууль тогтоомжийн тухай хуулиар шийдвэр гаргагчдад хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн санаа бодлыг заавал авч тусгах үүргийг хүлээлгэсэн.

Гэхдээ амьдрал дээр эдгээр хуулийн хэрэгжилт баталгаатай биш байна. Тухайлбал, хувь хүн болон аж ахуйн нэгжүүд нуусан хөрөнгөө ил тод мэдүүлэх тухай Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль нээлттэй хэлэлцүүлэг маргааны дараа 2015 оны 8-р сарын 7-нд батлагдсан юм. Гэтэл нөгөө талдаа, 2015 оны 8-р сарын 11-ны өдөр УИХ-ын Хууль зүйн байнгын хороо хаалттай хуралдаан

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

хийж Өршөөлийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэлэлцүүлгийг хийгээд иргэдийн санал бодлыг огт сонсохгүйгээр тэр өдөртөө эцэслэн баталжээ.

Зорилго 3.3.2.6

Дунд хугацаанд: Ихэнх нь

“11-11 төв” 2014 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Энэ төв иргэдийн санал хүсэлт, шүүмжлэл, гомдол зэргийг вэб сайт, телефон утасны дуудлага, цахим машин, биеэр зэрэг олон сувгаар хүлээн авч бүртгэн холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлүүлэх, иргэдэд утсаар болон мессэжээр хариу хүргүүлэх, нөгөө талаас Засгийн газрыг мэдээллээр ханган ажилласан. Засгийн газрын зүгээс уг төвийн үйл ажиллагаа амжилттай явагдаж байна гэж танилцуулдаг ч ХБТ-ын судлаачид үйл ажиллагааг нь үнэлсэн болон түүнийг батлах хөндлөнгийн нотолгоог олоогүй.

Тус төвд 2014 онд нийт 41960 гаруй хандалт бүртгэгдсэн ба 2015 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар 80 мянга гаруй санал, гомдол бүртгэгдсэн байна.² Хэдийгээр энэ системээр ирсэн санал, гомдлыг бүрэн харж болох ч төр, засгийн байгууллагуудын хэрхэн шийдсэнийг мэдэх боломжгүй юм. 2015 он гарсаар энэ төвийн ажлын эрч суларсан. 2014 оны 11 дүгээр сард Засгийн газар огцорсны дараа тус төвийн үйл ажиллагаа гомдол, санал хүлээн авах тал дээр хэвийн үргэлжилж байсан ч, сайд, агентлагын дарга нарын тогтсон цагт иргэдийн санал, хүсэлтэд шууд хариулт өгдөг үйл ажиллагаа зогссон болно.

Эцсийн хугацаанд: Ихэнх нь

Засгийн газрын өөрийн үнэлгээний эцсийн тайланд дурдсанаар, 2016 оны эцэс гэхэд 11-11 төвд иргэдээс барагцаагаар 125.000 санал, хүсэлт, гомдол хүлээн авчээ. Эдгээрээс 117.000 мянган тохиолдолд ямар нэг байдлаар хариу өгсөн байна. Үүнээс гадна уг төвд ирүүлсэн иргэдийн санал гомдолд хариу өгөх зорилгоор холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан 33 удаагийн шууд дамжуулалтын хэлэлцүүлгийг зохион байгуулж дамжуулсан гэж Засгийн газар мэдээлжээ.³ Гэхдээ хүлээж авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн, санал гомдол нь бодлогод хэрхэн нөлөөлсөн нь тодорхойгүй байна. Мөн санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэх явц, хариулсан байдал, авсан арга хэмжээг бүртгэн харуулдаг мэдээллийн тогтолцоо алга байна. Ингээд энэ зорилт бүрэн биелээгүй (ихэнх нь биелсэн) гэж үзлээ. Засгийн газрын өөрийн үнэлгээний тайланд ч мөн адил үзсэн байна.⁴

Зорилго 3.3.3.5

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

Нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар иргэдийн оролцоог хангаж батлан гаргасан шийдвэрийг хүчингүйд тооцон, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн хангалттай зохицуулалт бий болсонгүй. ХЗЯ-ны мэдээлсэнээр Захиргааны ерөнхий хуулийн төсөлд зарим зохицуулалт тусгасан боловч эцсийн хувилбарт нь ороогүй болно. Хэдийгээр ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ талаар байнга анхаарал хандуулж байгаа ч тайлант хугацаанд хэрэгжилт нь хязгаарлагдмал байна.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Эцсийн хугацаанд: Хязгаарлагдмал

Олон нийтийн саналыг аваагүй төрийн байгууллагын шийдвэрийг хүчингүй болгох, үүнд буруутай албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх талаар тодорхой зохицуулалт хийгдээгүй байна. 2015 оны 6-р сарын 19-нд баталсан Захиргааны ерөнхий хуулинд олон нийтийн ашиг сонирхол, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан захиргааны актыг батлагдсанаас хойш таван жилийн дотор хүчингүй болгох тухай заалт оржээ. Гэхдээ энэхүү хууль ҮАҮТ-ны хамрах хугацаанаас хойш буюу 2016 оны 7-р сарын 1-нээс үйлчилж эхэлсэн болно. Энэ зорилтын биелэлтийг хязгаарлагдмал гэж тодорхойлов. Засгийн газрын өөрийн үнэлгээний эцсийн тайланд мөн адил дүгнэсэн байна.⁵

Зорилго 3.3.3.7

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

Хууль сурталчлах, хуулийн зөвлөгөө, санал гомдол хүлээн авах, улсын бүртгэлийн зэрэг чиглэлээр хурал, семинар байнга зохион байгуулагдсан байна. Хууль Зүйн Яамны харьяа Хууль Зүйн Үндэсний Төв 2014 онд шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төслийн талаарх сургалт, хэлэлцүүлгийг хот, хөдөөгүй зохион байгуулжээ. Гэхдээ ихэнх нь иргэд олон нийтэд бус төрийн албан хаагчдад зориулагдсан байв.

Харин иргэдийн эрх зүйн мэдлэг, хуулиар дамжуулан эрх ашгаа хамгаалах чадавхиа дээшлүүлэхэд шууд чиглэсэн нэлээд ажил гол төлөв олон улсын төсөл, хөтөлбөрийн шугамаар хийгдэж байгаа болно. Тухайлбал, шинээр гарсан тодорхой хууль, журам, дүрмийн зохицуулалт, төрийн шинэ бодлого, шийдвэрийг энгийн ойлгомжтой хэлбэрт оруулсан гарын авлага, товхимол, зураг хуудас зэргийг байнга бэлтгэн гаргаж байна. Жишээлбэл, Авлигатай тэмцэх газраас “Баадай болон түүний гэр бүл” нэртэй нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хялбаршуулсан гарын авлагыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Мерси Кор байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” (APREAL) төслийн хүрээнд эрхлэн гаргасан байна. Гэвч иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагаа хангалтгүй байлаа.

Эцсийн хугацаанд: Хязгаарлагдмал

Шинээр батлан гаргасан хуулийн төслүүдийг юуны өмнө сурталчлан таниулах сургалт, семинарыг үе үе зохион байгуулж байв. Жишээлбэл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй тухай хуулийн заалтуудыг сурталчилсан. Засгийн газрын төгсгөлийн шатны өөрийн үнэлгээний тайланд дурдсанаар, төрийн байгууллагууд шинээр батлагдсан хууль тогтоомжуудыг сар тутам радио нэвтрүүлгээр танилцуулж байгаа ба энэ талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээг 2015 онд байгуулжээ.⁶ Төлөвлөгөөнд орсон зорилтууд тодорхой биш байсан чадавхи олгох үйл ажиллагааны тоо хангалттай хэмжээгээр нэмэгдсэн тухай тодорхой нотолгоо алга байгаа тул энэ зорилтын хэрэгжилтийг хязгаарлагдмал гэж үзлээ.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Засгийг нээлттэй болгосон уу?

Зорилт 3.3.2.1

Иргэний оролцоо: Бага зэрэг

Нийтийн сонголын тухай хууль (2016 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон), Захиргааны ерөнхий хууль (2016 оны 7-р сарын 1-нээс хэрэгжсэн), Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (2016 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон) ба Хууль тогтоомжийн тухай хууль (2017 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр)-иудыг тус тус батлан гаргаснаар иргэд, олон нийтийн оролцооны эрх зүйн таатай нөхцөл бүрдэж, улмаар зарим үр дүн гарч эхэлсэн. Жишээлбэл, зарим хуулийн төсөлд төрийн, төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэд болон олон нийтийн саналыг авах зорилгоор УИХ-ын www.parliament.mn цахим хуудсанд 30 хоногийн турш тавигдаж байна. Гэхдээ хуулиудын зарим нь ҮАҮТ-ний хэрэгжлтийн хугацаанд хүчин төгөлдөр болоогүй юм. Цаашдаа эдгээр хууль тогтоомжийг зөв хэрэгжүүлэх нь төрийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой болох юм. “Ил тод байдал сан” ТББ-ын Ц.Отгонсүрэнгийн мэдэгдсэнээр, төрийн үйлчилгээтэй холбоотой тогтоол шийдвэрийг гаргахдаа иргэд ба иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөхгүй байх нь түгээмэл практик хэвээр байна. Бас Дэлхийн банкны мэдээллээр бол Монгол улсын Засгийн газар зөвлөлдөх үйл явцын үр дүнг тогтмол мэдээлэхгүй байгаа ба талуудад ерөнхийлсөн, эсвэл хагас дутуу хариу өгдөг.⁷

Зорилт 3.3.2.6

Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

Иргэний оролцоо: Өөрчлөгдөөгүй

Төрийн хариуцлагатай байдал: Өөрчлөгдөөгүй

Энэхүү зорилт нь олон нийтийн зүгээс Засгийн газар үйл ажиллагааны талаар санал бодлоо хэлэх хялбар бөгөөд хүртээмжтэй сувгийг бий болгоход чиглэсэн. Иргэд долоо хоног бүр дунджаар 1000 орчим гомдол санал ирүүлдэг. Иргэд өөрийн мэдээллийг дуудлагын төв, цахим сайт, мэдээллийн үйлчилгээний цэг, гар утас, нийгмийн сүлжээ болон биеэр зэрэг 10 сувгаар ирүүлэх боломжтой.⁸ Гэхдээ нийт санал гомдлын 80 хувийг утсаар өгч байгаа юм.⁹ Бүх гомдол саналыг бүртгэж аваад 11-11.mn цахим хуудсанд төрийн байгууллагын хариултын хамт байршуулж байна. Гэхдээ 11-11 төв нь иргэдийн мэдээллийг 2012 оноос буюу ҮАҮТ-ний хэрэгжиж эхэлсэн хугацаанаас өмнө авч эхэлснийг дурдах хэрэгтэй. Цахим архивыг судалж үзэхэд 11-11 төвийн цахим хуудас 2014 оны 2-р сараас хойш төдийлөн өөрчлөгдөөгүй нь харагдлаа.¹⁰ Энэ утгаараа, иргэдийн хувьд гомдол, саналаа илэрхийлэх сувгууд өөрчлөгдөөгүй ба ҮАҮТ-ний хэрэгжилтийн хугацаанд ямар нэгэн байдлаар өөрчлөгдөж шинэчлэгдсэнгүй. Дүгнэж үзэхэд, энэхүү зорилтын хүрээнд иргэний оролцооны арга хэлбэр сайжраагүй байна.

Мэдээллийн хүртээмжийн тухайд гэвэл, 11-11 төв нь төрийн үйлчилгээний талаар маш олон тооны санал хүсэлт хүлээж авсан ч тэдгээрт үнэлгээ хийсэн тухай мэдээлэл алга байна. Жишээлбэл, тэдгээрээс хичнээн нь санал, шүүмжлэл ба гомдол гэсэн ангилалд хамаарах, цахим хуудсанд янз бүрээр тэмдэглэсэн байгаа ч үнэхээр шийдвэрлэсэн нь үү, үгүй юу гэдэг талаарх тодорхой мэдээлэл

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

алга байна. Мөн эдгээр мэдээллийг дээрх шалгуураар ангилах буюу тодорхой сэдвээр ирсэн санал гомдлуудыг нэгтгэж харах боломжгүй байна.

Төрийн хариуцлагатай байдлын тухайд, иргэд саналаа хэлж түүнийгээ цахим сайт дээр харах боломжтой ч тэдний гомдол санал нь Засгийн газрын үйл ажиллагаанд нөлөөлж чадахгүй байна. Засгийн газрын тайлагнаснаар, энэхүү систем нь одоогоор гомдлын мөрөөр арга хэмжээ авч чадахгүй учраас төрийн үйлчилгээг шууд сайжруулах боломжгүй байна гэжээ.¹¹ Үүнээс гадна зорилтод дурдсан, санал гомдлын мөрөөр хяналт тавих мэдээллийн системийг бий болгоогүй байна. Засгийн газрын зүгээс иргэдийн 117517 буюу хүлээж авсан нийт санал гомдлын 94 хувьд ямар нэгэн байдлаар хариулсан, мөн тэдний мөрөөр шууд хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан хэдий ч энэ бүхэн ҮАҮТ-ний хэрэгжиж эхэлсэн хугацаанаас өмнө хийгдсэн ажлууд байлаа.¹² Ингээд төрийн хариуцлагатай байдалд өөрчлөлт гараагүй гэж үзсэн болно.

Зорилт 3.3.3.5

Иргэний оролцоо: Өөрчлөгдөөгүй

Төрийн хариуцлагатай байдал: Өөрчлөгдөөгүй

Шинээр батлагдсан Захиргааны ерөнхий хууль иргэдийн илүү өргөн хүрээтэй оролцоог хангаж чадах боловч ҮАҮТ-ны хэрэгжилтийн хугацаа дуусахаас өмнө хүчин төгөлдөр болж үр дүнгээ өгч чадаагүй. Үүний улмаас төрийн нээлттэй байдалд өөрчлөлт гарсангүй.

Зорилт 3.3.3.7

Мэдээллийн хүртэмжтэй байдал: Өөрчлөгдөөгүй

Иргэний оролцоо: Өөрчлөгдөөгүй

Засгийн газрын зүгээс шинэ хууль тогтоомж, зохицуулалтыг танилцуулах, мөн хуулийн нэр томъёо, хэллэгийг олон нийтэд ойлгомжтой болгохын тулд радио нэвтрүүлэг бэлтгэж, сургалт, хичээл, семинар явуулж иржээ. Гэхдээ төрийн яам, агентлагуудаас төрийн албан хаагчдад зориулан зохион байгуулсан эдгээр сургалт семинарын зөвхөн заримд нь иргэдийг урьж оролцуулсан байна. Түүнээс гадна эдгээр арга хэмжээнүүд ҮАҮТ-ний хамрах хугацаанаас өмнө болжээ. Улмаар энэхүү зорилтын хэрэгжилт засгийн газрын практик үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлснийг нотлох тодорхой баримт жишээ алга байна.

Цаашилбал, иймэрхүү зорилтыг нөлөөлөх гэж буй хэсэг бүлгийн онцлогт сайтар тохируулах шаардлагатай бөгөөд тодорхой тооны төслүүдийг хэрэгжүүлж дуусгах ёстой.

Дараагийн ҮАҮТ-нд орсон уу?

Энэ бүлгийн эхний хоёр зорилт дараагийн ҮАҮТ-нд үргэлжлэн орсон болно. Тухайлбал, шинэ төлөвлөгөөнд Засгийн газрын 11-11 төвд иргэдийн гомдол саналыг авахад ашиглах гар утасны апплейшнийг боловсруулах, бас шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангахад чиглэсэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилт багтсан байна.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

¹ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011.06.06)
<http://www.legalinfo.mn/law/details/374>

² www.11-11.mn –с авсан энэ мэдээлэл 2016 оны 10-р сард 11-11 төв татан бүүгдсантай холбоотойгоор устсан байна. Татан бүүгдсэн талаарх мэдээллийг <http://www.olloo.mn/n/34429.html> -с үзнэ үү.

³ ЗГХЭГ. *Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016.* (НЗТ. 2016)
<http://bit.ly/2tnPaYS>. Шүүд хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл <http://www.olloo.mn/n/1995.html>

⁴ ЗГХЭГ. *Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016.* (НЗТ. 2016)
<http://bit.ly/2tnPaYS>

⁵ Өмнөх эх сурвалж

⁶ Өмнөх эх сурвалж

⁷ “Global Indicators of Regulatory Governance, Public Consultation in Rulemaking,” (The World Bank, 2017),
<http://rulemaking.worldbank.org/data/comparedata/consultation>

⁸ ЗГХЭГ. *Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016.* (НЗТ. 2016)
<http://bit.ly/2tnPaYS>

⁹ Б.Хүдэр. “11-11 төв 3 нас хүрлээ” (Монцамэ, 2015.10.12) <http://en.montsame.mn/politics/783>

¹⁰ ХБТ одоо байгаа www.11-11.mn цахим хуудсыг 2014 оны 2-р сар (<http://bit.ly/2pjNLnb>) болон 2012 оны 10-р сарын (<http://bit.ly/2pHVzyX>) хувилбартай нь харьцуулж үзсэн болно

¹¹ *Монгол улсын ҮАҮТ-II, 2016-2018.* (НЗТ.2016) <http://bit.ly/2tM0v7d>

¹² ҮАҮТ хэрэгжиж эхлэхээс өмнө болсон шүүд хэлэлцүүлэг <http://www.olloo.mn/n/1995.html>

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

5-р бүлэг: Төрийн үйлчилгээг сайжруулах

3.3.2.2: Төрийн үйлчилгээг цахимжуулах

Эхлэх хугацаа: Заагаагүй Дуусах хугацаа: 31/12/15

3.3.2.3: Нэг цонхны үйлчилгээг цахимжуулах

Эхлэх хугацаа: Заагаагүй Дуусах хугацаа: 31/12/15

3.3.2.4: Төрийн захиргааны үйлчилгээний нэгдсэн стандарт бий болгох

Эхлэх хугацаа: Заагаагүй Дуусах хугацаа: 31/12/15

3.3.2.5: ТҮЦ машины тоог нэмэгдүүлэх

Эхлэх хугацаа: Заагаагүй Дуусах хугацаа: 31/12/15

3.3.3.6: Хуулийн төсөл, захиргааны журам болон тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн цаг үед нь олон нийтэд хүргэх

Эхлэх хугацаа: Заагаагүй Дуусах хугацаа: 31/12/15

Хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ, МТШХХГ, Төрийн үйлчилгээ, төрийн захиргааны байгууллагууд

Хамтран ажиллах байгууллага: Тодорхойлоогүй

Редакцийн тэмдэглэл: ХБТ-ын судлаачид төрийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн зорилтуудыг нэг бүлэг болгов. ҮАҮТ-ний шинэчилсэн англи хувилбарт зорилт 3.3.2.5 гэж тусдаа байхгүй ч үйл ажиллагаа нь тусгагдсан байна.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэт гэл		Хунд хугацааны: Эцсийн	Засгийг нээлттэй болгосон уу?					
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээлэлтийн	Иргэний оролцоо	Нийгмийн хариуцлагатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой
3.3.2.2: Төрийнүйлчилгээг цахимжуулах			✓		✓			✓			✓					✓		✓			
3.3.2.3: Нэг цонхны үйлчилгээг цахимжуулах		✓			Тодорхойгүй					✓			✓					✓			
3.3.2.4: Төрийн захиргааны үйлчилгээний нэгдсэн стандарт бий болгох			✓		Тодорхойгүй					✓			✓					✓			
3.3.2.5: ТҮЦ машины тоог нэмэгдүүлэх				✓	✓			✓			✓		✓					✓			
3.3.3.6: Хуулийн төсөл, захиргааны журам болон тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн цаг үед нь олон нийтэд хүргэх				✓	✓			✓			✓	✓						✓			

Зорилго

Энэ бүлгийн зорилтууд төрийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн болно. Үүнд төрийн үйлчилгээний цахим хуудас ажиллуулах 3.3.2.2, нэг цонхны үйлчилгээг бий болгох 3.3.2.3, төрийн захиргааны үйлчилгээний нэгдсэн стандарт бий болгох 3.3.2.4, ТҮЦ машины тоог нэмэгдүүлэх 3.3.2.5, хуулийн төсөл, захиргааны журам болон тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн цаг тухайд нь олон нийтэд хүргэх 3.3.3.6 зэрэг орно.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Хэрэгжсэн байдал

Зорилт 3.3.2.2

2013 оны 11 дүгээр сарын 16-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Том төрөөс ухаалаг төр лүү” санаачилгыг танилцуулсан. 2015-2020 онд хэрэгжих “Ухаалаг засаг” төсөл нь иргэдийн оролцоог дэмжих механизмыг бүрдүүлэх, ухаалаг төрийн нэгдсэн тогтолцоог бий болгох, төрийн өгөгдөл мэдээллийн нээлттэй орчинг бий болгох болон төслийн удирдлага, зохион байгуулалт гэсэн дөрвөн үндсэн хэсгээс бүрдэх ба мэдээлэл, харилцаа холбооны техник технологи ашиглан Монгол Улсад төрийн үйлчилгээг үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгон сайжруулах зорилготой юм. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр түргэн шуурхай хүргэж иргэдийн мэдээллийн технологийн хэрэглээний тэгш бус байдлыг багасгах, төрийн лавлах үйлчилгээний хүртээмж, цар хүрээ нэмэгдүүлэх зэрэг тодорхой зорилтууд үүнд багтсан байна.

Энэхүү санаачилгыг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газар хэд хэдэн чухал алхамыг хийсэн. Тодруулбал, 2015 оны 6 дугаар сарын 8-нд “Ухаалаг засаг” төслийг 17.9 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлж хэрэгжүүлэх зээлийн гэрээнд Монгол Улсын Сангийн яам, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци гарын үсэг зурсан ба УИХ-аас уг гэрээг соёрхон баталлаа. Төслийн нийт зардал 20 сая ам.доллар.

Зорилт 3.3.2.3, 3.3.2.4

Дунд хугацаанд: Эхлээгүй

Нийслэл Улаанбаатар хот, хотын дүүргүүд болон аймгийн төвүүдэд иргэдэд үйлчлэх төвлөрсөн үйлчилгээний цэгүүд үйл ажиллагаа явуулж байна. Улсын бүртгэл, татвар, нийгмийн даатгал, банк санхүү, нотариатын үйлчилгээ нь ихэвчлэн тухайн орон нутгийн төр, захиргааны байгууллагын байранд хамтдаа байрладаг. Гэвч төрийн албан хаагч бүрт тус тусад нь хандах хэрэгтэй хэвээрээ байна. Уг зорилт нь олон төрлийн үйлчилгээг зөвхөн нэг төрийн албан хаагчид хандаж авах боломжийг иргэдэд олгох явдал юм. Тийм учраас ХБТ-ын судлаачид төрийн үйлчилгээг нэг цэгийн эсвэл нэг цонхны үйлчилгээнд шилжүүлсэн талаарх мэдээлэл олоогүй болно.

Зорилт 3.3.2.3 ба 3.3.2.4

Эцсийн хугацаанд: Эхлээгүй

Өөрийн үнэлгээний эцсийн тайланд дурдсанаар, 2016 оны 2-р сарын 8-нд Засгийн газар төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг ажиллуулах төлөвлөгөө болон ажлын хэсгийг байгуулжээ.¹ Гэхдээ төрийн нэг цэгийн үйлчилгээг зохион байгуулах ажил эхэлсэн тухай нотолгоо алга байна. Харин 2016 оны эхний хагаст Улаанбаатар хотын гурван дүүрэгт төрийн байгууллагын нэг цэгийн цонхны үйлчилгээний төв байгуулагджээ. Гэхдээ ҮАҮТ-нд дурдсан цахимаар үйлчлэх боломж бүрдээгүй байна. Ингээд ахиц өөрчлөлт гарсан тухай нотолгоо хангалтгүй байгаа учраас ХБТ-ын судлаачид энэ зорилт хэрэгжиж эхлээгүй гэж дүгнэсэн болно.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилт 3.3.2.5

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

2013 оны 6 дугаар сарын 19-нд Төрийн үйлчилгээний цахим машин буюу – ТҮЦ машин нээлтээ хийсэн. Хүн ам ихээр суурьшсан хот суурин газруудад ТҮЦ машиныг байрлуулсан бөгөөд уг машин нь төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санд холбогдсон болно. <https://datacenter.gov.mn/> цахим хуудсанд мэдээлсэнээр 2014 оны эхэн үеэс уг машины хэрэглэгчдийн тоо эрс нэмэгдсэн байна. Үндэсний Дата төвийн ажилтаны мэдээлсэнээр 2015 оны 7 дугаар сарын 1-ны байдлаар Улаанбаатар хотод 74, орон нутагт 30, нийт 104 ТҮЦ машин ажиллаж байв.

Иргэний бүртгэлийн 6 төрлийн, Гаалийн Ерөнхий Газартай холбоотой 4 төрлийн лавлагааг ТҮЦ машинаас авч болно. Зарим газарт иргэд цахилгаан эрчим хүчний төлбөрөө төлөх, өдөр тутмын сонин хэвлэл захиалах үйлчилгээг авч байна. Цаашдаа үүрэн холбооны операторууд, кабелийн телевиз, IP телевизүүдийн үйлчилгээний төлбөр төлөх, яам, агентлагуудын мэдээллийг оруулахаар төлөвлөж байна.

ЗГХЭГ, Хүний аюулгүй байдлын судалгааны төв ТББ-тэй хамтран сум, хороодод нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэхээр тохирсон. Гэвч энэхүү үйл ажиллагааны талаар ямар нэг мэдээлэл олдоогүй болно. Дээрх байдлыг харгалзан үзэж ХБТ-ын судлаачид эхний жилийн хугацаанд уг зорилтын хэрэгжилтийг хязгаарлагдмал гэж үзсэн болно.

Эцсийн хугацаанд: Хязгаарлагдмал

Засгийн газар өөрийн үнэлгээний эцсийн тайландаа дурдахдаа, төрийн үйлчилгээний цахим машин 21 аймагт 28, Улаанбаатар хотод 80-г суурилуулсан бөгөөд тэд бүртгэл, татвар хураамж, сонин борлуулалт ба орон сууцны төлбөрийн зэрэг үйлчилгээ үзүүлж байна гэжээ.² Эндээс үзэхэд, ажиллаж байгаа нийт машины тоо 108 байгаа нь ҮАҮТ-нд зорилт болгож дэвшүүлсэн 273-д хүргэнэ гэсэн тооноос бага байгаа юм.³ Ийм учраас энэ зорилтын хэрэгжилт хязгаарлагдмал хэвээр үлджээ. Засгийн газрын зүгээс тайлбар хийхдээ, орон нутгийн төр захиргааны байгууллагуудад албан бичиг явуулж төрийн үйлчилгээний цахим машин худалдаж авах зардлыг өөрсдийн төсөвт суулгаж санхүүжүүлэхийг санал болгоод байна.

Зорилт 3.3.3.6

Дунд хугацаанд: Эхлээгүй

Энэхүү зорилтыг хэрэгжүүлж эхлэхийн өмнө хуулийн төсөл, тогтоол, дүрэм журам УИХ болон холбогдох яамдын цахим хуудсанд тавигддаг байсан. Түүнчлэн зарим тохиолдолд УИХ-аас шинэ хуулийн төслийг яам, агентлаг, орон нутгийн засаг захиргааны байгууллага, засгийн газрын төслийн нэгжүүд рүү илгээж санал хүсэлтийг нь авдаг байв. ҮАҮТ-г хэрэгжүүлэх эхний жилийн хугацаанд төрийн үйлчилгээний цахим машин, иргэний танхим болон орон нутгийн нийтийн номын сангаар дамжуулан энэ чиглэлд ил тод байдлыг сайжруулах ямарваа нэг ахиц дэвшил гараагүй гэж ХБТ-ын судлаачид үзэж байна.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Эцсийн хугацаанд: Эхлээгүй

Хууль, зохицуулалт, эрх зүйн акт, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон баримт бичгүүдийг www.legalinfo.mn сайтад тогтмол байршуулж байна. Хуулийн төсөл ба түүнд хамаарах мэдээллийн парламентын алба ёсны www.parliament.mn, сайтад урьдын адил байршуулдаг хэвээрээ. Гэхдээ зорилтод амлалт болгосон хэрнээ хууль тогтоомжийн төслүүдийг Төрийн үйлчилгээний цахим машин, Иргэний танхим болон нийтийн номын сангуудад байршуулаагүй байна. ХБТ-ын судлаачид шинэ хууль тогтоомжийн хэлэлцэж батлах үйл явц урт хугацаанд үргэлжилдэг тул энэ зорилт хэрэгжихэд түвэгтэй гэж үзэж байна.

Засгийг нээлтэй болгосон уу?

Зорилт 3.3.2.2

Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

2012 оноос төрийн үйлчилгээг цахим болгох санаачлагууд 2015 онд зогсонги байдалд оржээ. Засгийн газар “Ухаалаг засаг” хөтөлбөрийн хүрээнд зарим нэг зүйлийг сайжруулсан. Жишээлбэл, 2015 оны 11-р сараас 2016 оны 6-р сарын хооронд гурван аймаг ба Улаанбаатар хотын дүүргүүдэд үл хөдлөх хөрөнгийн цахим бүртгэлийн системийг байгуулсан.⁴ Гэхдээ зорилтын хамгийн чухал хэсэг – төрийн үйлчилгээний цахим порталыг байгуулах ажил дуусаагүй байна. www.ezasag.mn портал сайтаар хамгийн чухал хэрэгцээтэй 25 үйлчилгээг үзүүлдэг болно хэмээн байн байн амалж байгаа.⁵ Гэхдээ 2017 оны 3-р сарын байдлаар уг портал үйлчилгээ үзүүлэхгүй байна. Энэ нь цахим гарын үсгийн үр ашигтай зохицуулалт байхгүйгээс болж байна. Үүнээс болж өөрчлөлт гараагүй, гацсан байна.

Зорилт: 3.3.2.3 ба 3.3.2.4

Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

Иргэний оролцоо: Өөрчлөгдөөгүй

Төрийн хариуцлагатай байдал: Өөрчлөгдөөгүй

Энэ хоёр зорилт ҮАҮТ-ны хугацаанд хэрэгжиж эхлээгүй болно.

Түүнээс гадна эдгээр зорилтууд нь нээлттэй засаглалын зарчимд хамаарахгүй, учир нь олон нийтэд зориулсан мэдээллийн тоо хэмжээ ба чанарыг сайжруулах, шийдвэр гаргахад иргэдийн оролцох боломжийг хангах, төрийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох арга замыг нэмэгдүүлэхэд чиглээгүй байна. Үүний оронд төрийн үйлчилгээний хүргэлтийг сайжруулж, засгийн газрын цахим үйлчилгээг өргөжүүлэхэд чиглэсэн байна.

Зорилт 3.3.2.5

Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

2014 оноос хойш Төрийн үйлчилгээний цахим машинаар нийт 16 төрлийн 3 сая гаруй нэгж үйлчилгээ үзүүлсэн гэж Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар тайлагнасан байна. Гэхдээ цахим машины тооноос гадна үйлчилгээний агуулгыг нэмэгдүүлэхээр зорилтод тусгасан нь дутуу биелжээ. Үүний улмаас иргэд өмнөхөөсөө илүү их мэдээлэл авдаг болсныг нотлох баримт байхгүй. Ингээд өөрчлөлт гараагүй гэж дүгнэсэн болно.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилт 3.3.3.6

Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

Зорилт хэрэгжиж эхлээгүй болохоор өөрчлөлт гараагүй, хуучнаараа байна. Иргэд хууль тогтоомжийн төслийг цахим машин, иргэний танхим ба нийтийн номын сангаас авч чадахгүй хэвээр байна.

Дараагийн ҮАҮТ-нд орсон уу?

Эдгээр зорилтын нэг нь ч Монгол улсын дараагийн ҮАҮТ-нд ороогүй болно.

¹ ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016. (НЗТ. 2016) <http://bit.ly/2tnPaYS>

² Өмнөх эх сурвалж

³ Монгол улсын Засгийн газрын НЗТ-ийн ҮАҮТ (Хавсралт). (Нээлттэй Засаг Түншлэл) <http://bit.ly/2mFW9eM>

⁴ "Implementation Status & Results Report – SMART Government," (The World Bank, 20 Jun. 2016), <http://bit.ly/2mTThvg>

⁵ "State services shifting to an online system," (News.mn, 23 May 2015), <http://www.news.mn/r/210357>. Мөн ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016. (НЗТ. 2016) <http://bit.ly/2tnPaYS>

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

6-р бүлэг: Хууль сахиулах ажиллагааг сайжруулах

3.3.3.1: Гэмт хэргийн гаралтын “цахим газрын зураг”-ийг ажиллуулах.

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

3.3.3.2: Хууль сахиулах үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн тогтолцооны нэгдсэн сан бүрдүүлж, холбогдох этгээдэд нээлттэй, хүртээмжтэй болгох

Эхлэх хугацаа: Заагаагүй

Дуусах хугацаа: 31/12/15

Хэрэгжүүлэх байгууллага:

ХЗЯ, Засгийн газар

Хамтран ажиллах байгууллага: Тодорхойлоогүй

Редакцийн тэмдэглэл: ХБТ-ын судлаачид хууль сахиулах үйл ажиллагаа, гэмт хэргийг бууруулах чиглэлийн эдгээр зорилтыг нэг бүлэгт хамруулсан болно.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэт гэл		Хунд хугацааны: Эцсийн		Засгийг нээлттэй болгосон уу?					
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээллийн	Иргэний оролцоо	Нийгмийн хариуцлагатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой	
3.3.3.1: Гэмт хэргийн гаралтын “цахим газрын зураг”-ийг ажиллуулах			✓		✓			✓			✓			✓							✓	
3.3.3.2: Хууль сахиулах үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн тогтолцооны нэгдсэн сан бүрдүүлэх			✓		Тодорхойгүй						✓			✓				✓				

Зорилго

Засгийн газар гэмт хэргийн гаралтын “цахим газрын зураг”-ийг боловсруулж ажиллуулах (3.3.3.1), хууль сахиулах үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн тогтолцооны нэгдсэн санг бүрдүүлэх (3.3.3.2) зорилго тавин ажиллалаа.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилт 3.3.3.1

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

2013 оны 6 дугаар сард Засгийн газрын мэдээлсэнээр ХЗЯ-ны төрийн нарийн бичгийн даргын А/53 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэмт хэргийн цахим газрын зураглалын системийг нэвтрүүлэх төслийг боловсруулах” ажлын хэсгийг байгуулсан. eCrimeMapping програм хангамжийг 2014 онд хийж дуусган <http://crimemap.police.gov.mn/> хаягаар ашиглалтад оруулсан болно. Энэ ажлыг Цагдаагийн Ерөнхий Газрын (ЦЕГ) Мэдээлэл технологийн төв, “Ай Си Ти Си Си” компанитай хамтран гүйцэтгэсэн болно. Энэхүү тайлант хугацааны дараа буюу 2015 оны 9 дүгээр сард тухайн портал албан ёсоор ажиллаж эхэлсэн. Иймд ХБТ-ын судлаачид уг зорилтын хэрэгжилтийг хязгаарлагдмал гэж үзэж байна.

Эцсийн хугацаанд: Хэрэгжсэн

Гэмт хэргийн цахим газрын зургийн портал сайт 2015 оны 9-р сараас ажиллаж эхэлсэн ба <http://crimemap.police.gov.mn/> хаягаар нээлттэй байна. Энэ системд 2011-2012 онуудад бүртгэгдсэн зарим ба 2013 оноос одоог хүртэл бүргэгдсэн бүх гэмт хэргийн мэдээлэл оржээ. Гэмт хэргийн мэдээллийг хулгай, дээрэм, хүчин зэрэг 11 ангиллаар, мөн хаана гарснаар нь газрын зураг дээр харуулжээ. Ингэхдээ гэмт хэргийн төрлөөр болон байршлаар нь зургаа зургаан сараар ялгаж харуулах боломжтой. хаана гарснаар нь гарсан Газрын зураг дээрх гэмт хэрэг бүрийн тэмдэглэгээ нь хэргийн дугаар, хэрэг гарсан хугацаа ба газар, мөн хамаарах цагдаагийн хэлтсийн мэдээллийг агуулдаг.

Зорилт 3.3.3.2

Дунд хугацаанд: Хязгаарлагдмал

Мэдээллийн нэгдсэн сан (гэмт хэргийн цахим зураглалтай ижил зарим мэдээллээс бүрдэнэ) үүсгэх талаарх 2 дахь зорилтын тухайд зарим нэг ажил хийгдсэн байна. 2015 оны 7 дугаар сард УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос энэхүү мэдээллийн нэгдсэн санг бий болох 23-р тушаалыг гаргасан болно. 2015 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр ажлын хэсэг байгуулагдсан ба ХЗЯ дахь төслийн удирдагчийн мэдээлсэнээр ажлын төлөвлөгөө 50-60 хувийн биелэлттэй явж байна.

Эцсийн хугацаанд: Хэрэгжсэн

Засгийн газрын өөрийн үнэлгээний эцсийн тайланд дурдсанаар, ЦЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төв 2016 он хүртэлх гэмт хэрэг, торгууль шийтгэл болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны 7 сая мэдээллийг төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ашиглах өгөгдлийн санд оруулжээ.¹ Энэ мэдээллийн санг сар тутам шинэчилдэг, гэхдээ зөвхөн дотоод ажлын зориулалтаар ашиглах ба олон нийтэд хаалттай. Гэхдээ эрх бүхий байгууллагуудад зориулсан, иргэдэд нээлттэй байх шаардлагагүй өгөгдлийн нэгдсэн сан байгуулна гэж зорилт дэвшүүлсэн байна. Үүнийг харгалзаад уг зорилтыг хэрэгжсэн гэж үзлээ.

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Засгийг нээлттэй болгосон уу?

Зорилт 3.3.3.1

Мэдээллийн хүртээмж: Томоохон

ҮАҮТ-нөөс өмнө Цагдаагийн байгууллага өөрийн сайтаар дамжуулан гэмт хэргийн гаралтыг мэдээлж, ЦЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төвөөс гэмт хэргийн бүртгэлтэй холбоотой мэдээллийг хүсэлт тавьсны дагуу өгдөг байсан. Гэхдээ иргэд гэмт хэрэг, түүний байр зүйн мэдээллийг цахимаар авах боломжгүй байжээ. Тэгвэл гэмт хэргийн өгөгдлийг <http://crimemap.police.gov.mn> сайтаар дамжуулан нээлттэй болгож байгаа энэ төрлийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах чухал алхам юм. Иргэд одоо гэмт хэрэг хаана гарсан, ямар хэрэг болохыг мэдэж авснаар хувийн аюулгүй байдлаа хангах, тухайн цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаанд үнэлэлт өгөхөд ач тустай болжээ. Засгийн газрын тайлагнаснаар, энэ цахим системд 70.000 бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл ороод байна.

Гэхдээ энэ системд зарим хязгаарлалт байна. Жишээлбэл, цахим диаграмаар болон жагсаалтаар харуулах цэсүүд судлаачид орж танилцах үед ажиллахгүй байв. Засгийн газрын тайланд, эдгээр боломжууд гэмт хэргийн илрүүлэлт, хэрэг болсон байршлын ангилал, мөн хэрэг гарсан хугацаа, долоо хоногийн өдрүүд зэрэг дүн шинжилгээг харуулна гэж дурдсан байв. Эдгээр цэснүүд ажиллахгүй байгаа тул иргэд гэмт хэргийн бүрэн дүр зургийг мэдэх боломжгүй байна. Түүнээс гадна энэ систем нь гэмт хэргийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл, тухайлбал, гэмт хэргийн төвлөрөл их байгаа “халуун цэгүүд”, гэмт хэргийн өсөлт бууралт, өгөгдлүүдийг татаж авах боломж, гэмт хэргүүдэд хийсэн цагдаагийн хэлтсийн дүн шинжилгээ, гэмт хэрэг их гардаг газар орны талаар иргэдэд хандсан сэрэмжлүүлэг өгч байх зэрэг боломжийг бүрдүүлэх нь илүү ач тустай байх болно.

Зорилт 3.3.3.2

Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

Иргэний оролцоо: Өөрчлөлдөөгүй

Төрийн хариуцлагатай байдал: Өөрчлөлдөөгүй

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, гэмт хэрэг ба зөрчлийн бүртгэлийн өгөгдлийн сан олон нийтэд хаалттай бөгөөд зөвхөн төрийн байгууллагуудын дотоод хэрэгцээнд ашиглахыг тооцвол энэхүү зорилтын биелэлт төрийг бүр илүү нээлттэй болгоход тус нэмэр үзүүлэхээргүй байна.

Дараагийн ҮАҮТ-нд орсон уу?

Эдгээр зорилтууд нь Монгол улсын дараагийн ҮАҮТ-нд ороогүй болно.

¹ ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016. (НЗТ. 2016) <http://bit.ly/2tnPaYS>

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

7-р бүлэг. Хөрөнгө орлогыг нээлттэй болгох замаар төрийн албаны шударга байдлыг бэхжүүлэх

3.3.3.3: Нийтийн албан хаагчдын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг санамсаргүй сонголтын аргаар шалгах арга нэвтрүүлэх

Эхлэх хугацаа: Заагаагүй.

Дуусах хугацаа: 2015 оны 12-р сарын 31.

3.3.3.4: Авлигын индекс өндөртэй байгууллагуудын нийтийн албан тушаалтны хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг цахим мэдээллийн сүлжээнд байрлуулах

Эхлэх хугацаа: Заагаагүй.

Дуусах хугацаа: 2015 оны 12-р сарын 31.

Хэрэгжүүлэх байгууллага: Засгийн газар, Хууль зүйн яам, Авлигатай тэмцэх газар

Хамтран ажиллах байгууллага: Тодорхойлоогүй

Редакцийн тэмдэглэл: ХБТ-ын судлаачид хөрөнгө орлогыг нээлттэй болгох чиглэлийн зорилтуудыг энэхүү бүлэгт хамруулав.

Зорилтууд	Тодорхой байдал				НЗТ-тэй холбоотой байдал				Нөлөө				Гүйцэтгэл		Хунд хугацааны: Эцсийн	Засгийг нээлттэй болгосон уу?					
	Үгүй	Бага	Дунд	Өндөр	Мэдээлэлгүйн	Иргэний оролцоо	Нийгмийн хариуцлагатай байдал	Технологи инноваци, ил тод байдал	Үгүй	Бага зэрг	Дунд зэрэг	Томоохон	Эхлээгүй	Дутуу	Ихэнх нь	Бүрэн	Муудсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг	Томоохон	Дорвийтой
3.3.3.3: Нийтийн албан хаагчдын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг санамсаргүй сонголтын аргаар шалгах арга нэвтрүүлэх			✓		✓	✓	✓				✓	✓						✓			
3.3.3.4: Авлигын индекс өндөртэй байгууллагуудын нийтийн албан тушаалтны хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг цахим мэдээллийн сүлжээнд байрлуулах			✓		✓	✓	✓				✓	✓	✓					✓			

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Зорилго

Авилгатай Тэмцэх Газар төрийн албан хаагч бүрийн гаргаж өгсөн хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах боломжгүй тул төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг санамсаргүй сонголтын аргаар шалгах арга нэвтрүүлэх (3.3.3.3), авлигад өртөх магадлал өндөртэй байгууллагуудын албан тушаалтуудын хөрөнгө орлогын нээлттэй болгох (3.3.3.4) зорилтуудыг тавьсан болно. Үүний үр дүнд, засгийн газар зөвхөн санамсаргүй аргаар сонгогдсон төрийн албан хаагчид, мөн ашигт малтмал, газрын бүртгэл зэрэг авлигад өртөх өндөр магадлалтай салбарын албан хаагчдыг хянан шалгах болно.

Зорилго 3.3.3.3

Дунд хугацаанд: Эхлээгүй

Монгол улс 2012 оны 5-р сараас эхлэн төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэх үүднээс Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмыг батлан гаргасан. Үүний үр дүнд, улс төрийн ба төрийн жинхэнэ албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч эдгээрээс төрийн өндөр албан тушаалтан 240 хүний мэдүүлгийн хураангуйг нийтэд танилцуулах ёстой юм. Харин ашиг сонирхлын зөрчлийн тухай зохих хууль, журманд тусган оруулсан ч хэрэгжилт тааруу байна.

Нийт 40 000 төрийн албан хаагчийн мэдүүлгийг нэг бүрчлэн шалгах боломжгүй учраас цаашид олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомжуудын жишгээр санамсаргүй сонголтын аргаар шалгадаг болох саналыг иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс дэвшүүлж байна. Нээлттэй Нийгэм Форумын гүйцэтгэх захирал, НЗТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн энэхүү саналыг гаргаж бусад иргэний нийгмийн байгууллагууда болон АТГ дэмжиж ҮАҮТ-д оруулсан. АТГ-аас энэ асуудлыг судалж байгаа гэсэн мэдээлэл өгсөн ба ҮАҮТ-г хэрэгжүүлсэн эхний жилд ямар нэг ахиц дэвшил гараагүй болно.

Эцсийн хугацаанд: Эхлээгүй

2015 ба 2016 онд АТГ-с 240 орчим төрийн өндөр албан тушаалтны хөрөнгө орлогын мэдээллийг өөрийн <http://iaac.mn> сайтад нийтэлсэн. Энэ нь Авлигатай тэмцэх хуулийн дагуу мэдүүлгээ өгсөн 40 мянган албан тушаалтны маш бага хэсэг боловч хэвлэл мэдээлэл ба олон нийтийн анхаарлыг маш их татсан болно.¹ Засгийн газрын тайланд дурдсанаар, АТГ нь гараар боловсруулах ажилд маш их цаг хугацаа зарцуулдгийн улмаас жил бүрийн нийт мэдүүлгийн зөвхөн 1-2 хувийг шалгаж амждаг юм.² Үүнээс үзэхэд, Авлигийн эсрэг хуулинд өөрчлөлт оруулж, мэдүүлэг гаргадаг төрийн албан хаагчдын тоог цөөрүүлэх, эсвэл санамсаргүй сонголтын аргаар шалгах зарчмыг нэвтрүүлэх шаардлагатай. ҮАҮТ-ны хугацаа дуусахаас өмнө энэ аргыг нэвтрүүлээгүй. Ийм учраас энэ зорилт хэрэгжээгүй гэж үзлээ.

Зорилт 3.3.3.4

Дунд хугацаанд: Эхлээгүй

Авлига, хээл хахуульд өртөх магадлал өндөртэй Ашигт Малтмалын Газар, орон нутгийн засаг захиргаа, газрын бүртгэлийн албадын албан хаагчид руу чиглэж байна. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй нь <http://iaac.mn> цахим хуудсанд

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

нээлттэй болдог 240 өндөр албан тушаалтаны дотор авлигад эдгээр байгууллагын холбогдох албан тушаалтанууд орсон ч доод шатны албан тушаалтануудын хөрөнгө орлогын мэдүүлэг хаалттай хэвээр байна.

Эцсийн хугацаанд: Эхлээгүй

Дунд хугацааны үнэлгээнээс хойш энэхүү зорилтын биелэлтэнд ахиц дэвшил гарсангүй. Төрийн дунд доод түвшний албан тушаалтнуудын мэдүүлэг хаалттай хэвээр байна. Бас зорилтод тусгасан иргэдийн хяналтыг талаар ямар нэгэн мэдээлэл алга байна.

Засгийг нээлттэй болгосон уу?

Зорилт 3.3.3.3

Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

Төрийн хариуцлагатай байдал: Өөрчлөгдөөгүй

Төрийн албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг санамсаргүй сонголтын аргаар нээлттэй болгох систем ҮАҮТ-ны хугацаанд хэрэгжээгүй. АТГ 240 мэдүүлгийг зарласан ч энэ нь дээрх системийн дагуу хийгдсэн ажил биш юм. Ийм учраас дэвшүүлсэн зорилтод хамаарахгүй. Үүнийг харгалзаад Хараат бус тайлагналын судлаачид энэхүү зорилт нь нээлттэй засаглалын одоогийн түвшинг сайжруулаагүй гэж үзлээ.

Зорилт 3.3.3.4

Мэдээллийн хүртээмж: Өөрчлөгдөөгүй

Иргэний оролцоо: Өөрчлөгдөөгүй

Төрийн хариуцлагатай байдал: Өөрчлөгдөөгүй

Энэ зорилт хэрэгжиж эхлээгүй, авлигын эрсдэл өндөртэй төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэг үндсэндээ хаалттай хэвээр байгааг харгалзан үзвэл мэдээллийн хүртээмжид ямар нэгэн ахиц гарсангүй. Энэ зорилтын олон нийтийн оролцоо, төрийн хариуцлага, иргэдийн хяналт гэсэн санаанууд хэрэгжээгүй байна.

Дараагийн ҮАҮТ-нд орсон уу?

Эдгээр зорилтууд Монгол улсын дараагийн ҮАҮТ-нд ороогүй. Санамсаргүй сонголтын аргаар шалгах асуудал хоёр дахь төлөвлөгөөний анхны 28 зорилтын тоонд багтаж байсан хэдий ч эцсийн хувилбарт ороогүй юм. Гэхдээ шинэ төлөвлөгөөнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар авлигатай тэмцэх зорилт дэвшүүлснийг тэмдэглэж байна.

¹ Oyungerel Munkhbat, "Who's the richest politician in Mongolia?" (The UB Post, 26 May 2016), <http://bit.ly/2oP7Dgo>

² ЗГХЭГ. Монгол улсын НЗТ-ийн 2014-2016 оны ҮАҮТ. Өөрийн үнэлгээний эцсийн тайлан 2016. (НЗТ. 2016) <http://bit.ly/2tnPaYS>

Олон нийтээс санал авах хувилбар. Иш татахгүй байхыг хүсье.

Аргачлал

Энэхүү тайланг төр, засгийн хөтөлбөрүүд, хуулийн төсөл, зохицуулалт, засгийн газрын тогтоолууд, засгийн газрын өөрийн үнэлгээний эцсийн тайлан, хэвлэл мэдээллийн эх сурвалж болон гуравдагч талын тайланг үндэслэн гаргасан. Мөн ХБТ-ын судлаачид голлох оролцогчид, салбарын мэргэжилтэнүүдтэй ярилцлага хийж, зорилтууд болон тэдгээрийн үр дүнгийн талаар нэмэлт мэдээлэл авсан болно. Ярилцлага өгсөн хүмүүсийг тайланд иш татан дурдсан болно.

Загдрагчаагийн Батболд, Дэмбэрэлийн Цэрэнжав нар нь нээлттэй засаглалын чиглэлээр мэргэшсэн судлаачид болно. Нээлттэй Засаг Түншлэл нь засаглалыг сайжруулахын тулд төрийн ил тод байдлыг дэмжих, иргэдийг чадавхжуулах, авлигатай тэмцэх, шинэ технологийг нэвтрүүлэхэд чиглэсэн тодорхой зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтийг нь дэмждэг. Хараат Бус Тайлан нь яриа хэлэлцүүлгийг өрнүүлэх, хариуцлагатай байдлыг сайжруулах зорилгоор ҮАҮТ-г боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц, үр дүнг үнэлэн дүгнэдэг.

